

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-36

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны урсгал зардлын “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж”-ийн зарцуулалтын талаар Сангийн яам, Үндэсний аудитын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох	4-36
---	------

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 06 дугаар сарын 18-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Д.Батбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа;

Тасалсан: Д.Батлут, Г.Дамдинням, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа.

***Нэг.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны урсгал зардлын
“Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж”-ийн
зарцуулалтын талаар Сангийн яам, Үндэсний аудитын газар болон
холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Монгол Улсын Шадар сайдын Өрсөлдөөний асуудал эрхэлсэн Ажлын албаны дарга Б.Ганболд, шинжээч А.Даваасүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Баясгалан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Санхүүгийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Батзаяат, мөн яамны Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн санхүүгийн тайлан хариуцсан шинжээч бөгөөд ерөнхий нягтлан бодогч С.Лхам, Монгол Улсын сайд, 20 минутын хот, Үндэсний хорооны ажлын албаны дарга Ц.Оюундарь, Гадаад харилцааны яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Монгол Улсын Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын

газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн ахлах зөвлөх П.Баянбаатар, референт Ш.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны урсгал зардлын “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж”-ийн зарцуулалтын талаарх Сангийн яамны мэдээллийг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Үндэсний аудитын газрын мэдээллийг Монгол Улсын Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ж.Батжаргал, Б.Заяабал, Ж.Баярмаа, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Монгол Улсын Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, М.Санжаадорж нар үг хэлэв.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 17 цаг 12 минут.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Батбаяр: Бусад ирцдээ орсон гишүүдийг дуудаарай манай ажлын хэсгийнхэн. Тэгээд Зарлагын хяналтын дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 116.1-д заасны дагуу Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагууд болон бусад байгууллагуудын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно гэж заасан байдаг. Энэ хуульд заасны дагуу өнөөдөр мэдээлэл авах хурлыг эхлүүлж байна.

Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж хуралдааны ирц 58.3 хувьтай бүрдсэн тул Дэд хорооны 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ. Өнөөдрийн хуралдаанд Батбаяр миний бие, мөн Ренчиндоржийн Батболд гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, мөн Банзрагчийн Түвшин гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн тус тус хүрэлцэн ирсэн байна аа.

Дэд хорооны хэлэлцэх асуудлыг танилцуулна.

Энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны урсгал зардлын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зарцуулалтын талаар Сангийн яамнаас мэдээлэл сонсоно. Аудит байх ёстой шүү дээ аудит хаана байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Санал байхгүй тул дээрх асуудлыг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсэг байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Лхагважавын Гангэрэл ирсэн байна. Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Батаагийн Ганболд ирсэн байна. Монгол Улсын Шадар сайдын Өрсөлдөөний асуудал эрхэлсэн ажлын албаны шинжээч Ариунболдын Даваасүрэн ирсэн байна. Монгол Улсын сайд, 20 минутын хот, Үндэсний хорооны ажлын албаны дарга Цагааны Оюундарь ирсэн байна. Боловсролын яамны ТНБД Батжаргал ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Энхтөр дарга ирсэн байна. ЭХЯ-ны Хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт ирсэн байна. Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг дарга ирсэн байна. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд дарга ирсэн байна. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж дарга ирсэн байна. БХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Найдангийн Цэвэлмаа дарга хүрэлцэн ирсэн байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын

газрын дарга Намжингийн Нямхүү дарга ирсэн байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Шагдардоржийн Батзаяат дарга ирсэн байна. Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эдэнэ дарга, ГХЯ-ны Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Болдын Отгонцэцэг дарга ирсэн байна. Боловсролын яамны санхүүгийн хэлтсийн дарга Эрдэнэ-Очирын Адьяасүрэн дарга ирсэн байна. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах дарга. Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Мөнхсүх дарга ирсэн байна. Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын ахлах аудитор Жаргалсайханы Нямцэцэг, ХХААХҮЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч ерөнхий нягтлан бодогч Цэрэнпунцагийн Амгалан дарга хүрэлцэн ирсэн байна аа.

Дэд хорооны өнөөдрийн хуралдаанаар Төсвийн хуулийн 8.10.2-т заасны дагуу Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газар санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны урсгал зардлын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зарцуулалтын талаар Сангийн яамны мэдээллийг сонсоно.

Дэд хорооны гишүүд Сангийн яам, Үндэсний аудитын газар, бусад холбогдох байгууллагууд, албан тушаалтнуудаас нэмэлт мэдээлэл авна өнөөдөр.

Сангийн яамны мэдээллийг Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж даргад танилцуулна. 5 дугаар микрофон дээрээс танилцуулчих уу? Индэр дээрээс танилцуулчих.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж та бүхний энэ өдрийн амрыг эрье.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжтай холбоотойгоор Сангийн яамны зүгээс бэлдэж ирсэн мэдээллийг та бүхэнд танилцуулъя.

Уг мэдээлэлтэй холбоотойгоор бол 4 үндсэн агуулгаар та бүхэнд танилцуулга хийнэ. Ер нь хууль эрх зүйн хувьд ямар зохион үзүүлэлт байдаг юм бэ? Дараа нь бол олон улсын энэ ангилал дээр ямар байдлаар энэ ингээд туссан байдаг юм бэ? Мөн гүйцэтгэлийн хувьд ямар байдлаар гүйцэтгэл гарсан байна? Тэгээд эцсийн сүүлд нь бол ер нь энэ дүн шинжилгээний хувьд ямар дүгнэлт хийж байгаа вэ гэдэг талаар танилцуулъя. Ер нь яах вэ энэ төсөв маань бол өөрөө бол нэг талдаа төрийн үйлчилгээг хүргэх зорилготой байдаг. Гэхдээ нөгөө талдаа төр өөрөө бас төрийн үйлчилгээгээ хүргэхийн тулд өөрөө сервис үйлчилгээ бол хувийн хэвшлээс авах шаардлагатай байдаг.

Тэгэхээр энэ тасгийг энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бол үндсэндээ энэ эдийн засгийн ангилал дээр бол бид зорилтыг бол хэрэгжүүлдэг ийм байгаа. Ер нь энийг бол энэ IMF-ийн говермент финаншиал статистикс гээд GFS гэж бид ярьдаг. 2014 гэдэг энэ ангиллаар бол бид одоо манай улс бол төсвөө бүртгэж явж байгаа. Энэ ангилал дээр бол бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг англиар нь хэлэх юм бол purchases of goods and service гэж нэрлэж байгаа ямар зардлуудыг яг энэ онол дээрээ статистикийн тэр зөвлөмж дээрээ гарын авлага дээрээ гэх юм уу даа бүртгэж болно, бүртгэж болохгүй вэ гэдгийг бол зааж өгсөн

байдаг. Маш энгийнээр хэлэх юм бол ер нь бол гуравдагч этгээдээс Засгийн газар авч байгаа үйлчилгээг энэ дээр бүртгэнэ гэсэн ийм агуулга байгаад байдаг. Ингээд ямар ажил зөвшөөрдөг, зөвшөөрдөггүйгээр нь ялгасан нь энэ байна. Дараачийн ээлжид бол ер нь энэ GFS-ээр бол энэ эдийн засгийн ангиллуудыг яаж ангилдаг нь энд гарч ирж байгаа. Хэрвээ та бүхэн энэ дээр ингээд харах юм бол урд талдаа бол кодтой байгаа. Код бол нэг орон тоогоос эхлээд 4 орон тоо хүртэл ингээд кодчилсон байгаа. Манайх бол яг ийм байдлаар кодчилсон. Өөрөөр хэлбэл 2 дээр бол бүх зардлуудынхаа урсгал зардлынхаа нийт саммыг авч байгаа. Тэгээд хоёроосоо 21 гээд эхлэнгүүт нэг бүлэг эдийн засгийн ангиллууд гарч ирээд үүнээсээ цаашаа ингээд явчхаж байгаа ийм зүйл байгаа.

Энэ зөвлөмжийнх нь дагуу энэ IMF-ийн энэ GFS-ийг IMF-ийн гишүүн орнуудын ашигладаг энэ GFS гэдэг энэ ангиллын дагуу Сангийн сайд бол мөн Төсвийн тухай хуульд заасны дагуу энэ эдийн засгийн ангиллыг батлах эрхтэй байдаг. Тэр дагуу бол 2015 онд баталсан хамгийн сүүлд баталсан энэ эдийн засгийн ангиллын код нэр тайлбартайгаар бол бид нар энэ эдийн засгийн ангиллын ашиглаж байгаа. Баруун гар талд нь та бүхэн харах юм бол 2021 08 гэдэг нь бол энэ бүлгийн дугаараараа өөрөөр хэлбэл нэгтгэсэн сан нь тэнд очдог.

Тэгээд ерөнхий тайлбар нь тэнд байгаа баруун гар талд нь байгаа. Тэгээд 2218 мэтээр 809 хүртэл бол энэ ангилал явдаг байгаа. Тэгэхээр энэ зориулалтаар л энэ эдийн засгийн ангилал дээр бүртгэх боломжтой гэсэн үг болж байна гэсэн үг.

Дараагийн ээлжид болохоороо ер нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг бол бид ер нь аль зориулалтаараа яаж харагдаж байна вэ гэдгийг бол ашиглах харуулах гэж үзлээ.

Эхнийх нь хүснэгтийг та бүхэн харах юм бол энэ эдийн засгийн ангиллаараа бол ингээд батлагдсан, Улсын Их Хурлаар баталсан гүйцэтгэлийн хэмжээгээр бол байж байна гэсэн үг. 2023 онд бол нийтдээ 1 их наяд 43 тэрбум төгрөг батлагдаж байсан бол 2024 онд бол 1 их наяд 395.9 тэрбум төгрөг бол зарцуулагдсан байна гэдэг нь харагдаж байна.

Эдийн засгийн ангилал дээр бол зөвхөн эдийн засгийн ангиллаас гадна бол бусад бид нар ангиллаар бол төсвөө ялгаж хардаг. Энэний гол зорилго бол хэрвээ төрийн албан хаагчаар жишээ авах юм бол төрийн албан хаагч шиг эрэгтэй эмэгтэй насны ангиллаар нь 20-оос 30 насны, 30-аас 40 насны гэдэг юм уу тэгээд дээрээс нь төрийн захиргааны, төрийн үйлчилгээний гэж бас ялгаж болно. Мөн гүйцэтгэлээ хангалттай биелүүлсэн биелээгүйгээрээ ч гэдэг юм уу ийм байдлаар бүх талаас нь ялгаж болдог. Тэгээд яг тухайлсан нэг хүний хувь дээр гарч ирэх юм бол жишээ нь Санжаадоржийг яаж ялгах вэ гэхээр Сангийн яаманд ажилладаг төрийн захиргааны албан хаагч тэгээд насны ангиллын хувьд тэд сүүлийн жилүүдэд яг тийм үнэлгээтэй гэдгийг бүгдийг нь нийлүүлээд харах юм бол энэ өөрөө цогц мэдээлэл болж байна гэсэн зүйл харагдаж байгаа юм.

Эсрэгээрээ бол юу гэдэг юм 20-оос 30 насны төрийн албан хаагчид бол ингээд тэд байна гэдэг тоо бол ерөнхий дата анализын мэдээлэл болчхож байна гэсэн үг. Тэрэнтэй яг ижилхэн төсвийн ерөнхийлөн захирагч нар нь задлах юм бол баруун талын хүснэгт дээр та бүхэн харж байна. Хаана ямар төсөв харагдаж байна гэдэг зүйл. Жишээ нь орон нутгийн засаг захиргаа гэдэг дээр бол 319 тэрбум байсан 419 тэрбум төгрөг 100 тэрбум төгрөгийн зөрүүтэйгээр байж байна гэсэн үг.

Тэгэхээр эндээс бид нар цаашаа нарийвчилж нарийвчилж харж байж анализаа зөв хийх шаардлагатай болж байна гэсэн үг харагдаж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл дараачийн ээлжид бол бид нар хөтөлбөрөөр ангилж харж болж байна. Мөн зориулалтаар голынх нь хүснэгт тиймээ үндсэн үйл ажиллагааных уу, гадаад зээлийнх үү гэдэг байдлаар тиймээ. Жишээ нь энэ гарчихсан байгаа.

Дараачийн ээлжид бол бид нар энэ юунуудаа бусад энэ ангиллаар нь яаж харах вэ гэдгийг бол харагдаж байна аа. Бусад гэдэг нь бол хөтөлбөр, зориулалт мөн байршлаар нь бид нар ялгаж болж байна.

Дараачийн ээлжид бол зориулалт арга хэмжээгээр нь бол жишээ нь Сангийн сайдыг бол тусгайлан жишээ болгож авч оруулсан байгаа. Жишээ нь Сангийн сайдын багц дээр зөвхөн эдийн засгийн ангиллаараа харлаа гэх юм бол та бүхэн хамгийн дээд талд нь байгаа 220 тэрбум төгрөг байж байгаад 271 тэрбум төгрөг зарцуулсан байна гэдэг нь харагдчихаж байгаа юм. Гэхдээ дотор нь бид нар энийг зориулалтаар нь задлаад харах юм бол 150 тэрбум төгрөг нь бол гадаад зээлээр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний зарцуулалт байна гэдэг нь харагдаж байна.

Дараачийнх нь 45 тэрбум төгрөг нь тусламжаар гүйцэтгэх гэх мэт. Нөгөө талдаа бол бид нар энийг байгууллагаар нь харж байж бүрэн анализ хийх боломжтой болно. Жишээ нь Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл буюу Мянганы сорил сангийн энэ төсөл дээр хамгийн том зардал бол гарч байжээ гэдэг бол харагдаж байна гэсэн үг. Үүнтэй ижилхэн бол Боловсролын сайдын багц дээр бол бас энэ анализыг харж хийж болно. Ингээд харах юм бол Боловсролын сайдын хөтөлбөрөөр нь үзэх юм бол дийлэнх зардал нь бол ерөнхий боловсрол хөтөлбөр дээр гарч байна аа. Өөрөөр хэлбэл сургууль гэсэн үг. Тийм ээ. Гэтэл бол СӨБ гэдэг дээр арай бага тоо байдаг юм уу ингээд харагдаж байна гэсэн үг.

Нөгөө талдаа энийг бол зориулалтаар нь харж болно. Дотуур байрны үйлчилгээ дээр ямар зардал гарч байсан, байр ашиглалтын үйлчилгээ дээр ямар зардал гарч байсан бэ гэдгийг бол ингээд харж болж байна. Мөн нөгөө талдаа төсвийг нь төвлөрүүлэн захирагчаар нь эсвэл байгууллага бүрээр нь харж болно гэсэн үг.

Боловсролын сайдын хувьд бол 1300 орчим цэцэрлэг, 800 гаруй сургууль байгаа. Ингээд нийтдээ Боловсролын сайдын нөхцөл бол 2200, 2300 орчим тийм байгууллага байгаа. Энэ байгууллага болгоноор нэг бүрчлэн харж болох нь гэдэг санаа гарч ирж байна.

Тэгэхээр дараачийн ээлжид бол энэ одоо жишээ нь тусгайлан хүүхэд хөгжил хамгаалал гэдэг энэ хөтөлбөр дээр бид нар энэ эдийн засгийн ангилал ямар байдлаар гүйлгээ гарч байна вэ гэдгийг та бүхэнд харуулах гэж үзсэн.

Тэгэхлээр энэ 2023 оны хувьд бол яг энэ зорилгоор бол жишээ нь 609 гүйлгээг шуурхай үйлчилгээний зориулалтаас бол бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр гэдэг эдийн засгийн хяналтаас гарсан байна. Нөхөн сэргээх үйлчилгээний зориулалтаас 4999 гүйлгээ гарсан байна. Урьдчилан сэргийлэх үйлчилгээнээс нийт 2778 гүйлгээ гээд бусад зориулалтаар 191 гүйлгээ гэдэг гарсан байна гэдэг нь харагдаж байгаа юм. Энүүгээр зүгээр юуг хэлэх гээд байна вэ гэхлээр энэ эдийн

засгийн ангилал маань өөрөө бид нар Сангийн яаман дээр гүйлгээ хийхдээ бол төсвийн хуулиараа бол төсөв болгон бол төсвийн бүх ангилалд бол хуваарилагдсан байх ёстой гэдэг заалттай. Өөрөөр хэлбэл аль нэг байгууллага дээр байхгүйгээр эдийн засгийн ангиллаас гүйлгээ гаргаж болохгүй.

Аль нэг зориулалт хөтөлбөр дээр аль нэг төсөв дээр харьяалахгүйгээр улсын төсөв нэг Нийгмийн даатгалын төсөв ч гэдэг юм уу болохгүй гэдэг санаа гарч ирж байгаа юм. Ингээд гүйлгээнүүд хийчихсэн. Энэ гүйлгээг бол одоо Сангийн яам энэ жилээс эхлээд бол цахимаар ямар зориулалтын зүүн гар талынх нь бол ямар нэртэй зориулалтаас энэ эдийн засгийн ангиллаар зардал гарсан бэ гээд байна. Гарсан зардал нь ямар шинж чанартай байна вэ гэдэг нь бол баруун талд нь гарч ирээд байгаа юм.

Баруун гар талд нь гарч ирж байгаа зардлууд бол бусад энэ зардлууд гарч ирж байна гэж хэлж болохоор байна. Энэ гүйлгээний тоонуудыг мөн бид нар төсвийнх нь төрлүүдээр нь саяын миний хэлдгээр гаргаж ирж байна. Жишээ нь дээрээс нь харах юм бол бараа 360 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 772 сая төгрөг гэх мэт ингээд гарсан байна гэдэг нь бол бид нар энэ 2023 оны энэ гүйлгээ дээрээс бол анализ хийх боломжтой болж байна гэдэг ийм санаа гарч ирж байна гэсэн үг болчхож байна гэсэн үг.

Ингэхээр нэг гүйлгээний хувьд бол жишээ нь үнийн дүн ийм байна, дунд нь байгаа нь бол нэг гүйлгээний дундаж зарлага ер нь хэдэн төгрөг гардаг юм байна гэх мэт ингээд явчхаж байна гэсэн үг.

Ингээд цахимаар бол бид нар ийм дэлгэрэнгүй байдлаар бол яг энийг нэр төрөл болгоноор нь ялгачхаж байгаа. Эндээс бол дүгнэлт хийх юм бол жишээ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ гэдэг эдийн засгийн ангилал маань өөрөө гуравдагч этгээдээр буюу төсвийн байгууллага төсвийн байгууллага хоорондоо гэхээсээ илүү хувийн хэвшлийн байгууллага юу байдаг юм тэ ТББ Ийм байгууллагуудтай хийх харилцахад ашигладаг ийм эдийн засгийн ангилал байх ёстой. Нөгөө талдаа энэ эдийн засгийн ангиллаас бол бараа үйлчилгээний зардал бол уг нь гарах ёсгүй. Жишээ нь шатахууны зардал байдаг юм уу шатахууны зардлыг шатахуун гэдэг зориулалтынх нь өөрийнх нь зардал байсаар байтал энэ зардлаас гарч байвал болохгүй байх нь гэдэг зүйл ингээд харагдаж байгаа юм. Тэгэхээр энийг бол илүү бид нар цахимжуулаад энэ олон гүйлгээний тоог маш олон гүйлгээ байгааг бол бид нар жигдрүүлэх ийм ийм арга хэмжээ аваад цахимжуулаад явж байна аа.

Дараагийн төсвийн жилээс бол буюу 2026 оны төсөв дээр бид нар энэ эдийн засгийн ангиллын ямар байдлаар харах вэ гэдгийг бол ингэж байгаа. Одоо энэ жилийн хувьд бол гарч энэ эдийн засгийн ангилал дээр 1.7 их наяд төгрөг зарцуулагдсан байгаа. Өмнөх 2 жил болон энэ жилийн гарч байгаа гүйлгээнүүдийг харж байхад бол төсвийн тодотголоор бид яг саяынх шиг цэвэрлэж болох яг гуравдагч этгээд рүү чиглээгүй ийм зардлуудыг бол бууруулахаар төсвийн тодотголын төсөл дээр тооцоолоод оруулчихсан байгаа.

Цаашдаа бол хэрэгцээ шаардлагаа бол яг ийм байдлаар харна. Мөн цахимжуулалтынх нь давуу талыг бол ашиглаад яг одоо ийм нэр төрлийн шинж чанартай зардлуудыг бол гаргана аа. Тэрнээс биш бусад зардлуудыг эндээс гаргахгүй гэдэг ийм одоо ерөнхийдөө бол бодлого баримтлаад явж байгаа. Ер нь

зүгээр энэ эдийн засгийн ангиллын хувьд бол эдийн засгийн ангилал гэдэг маань бол өөрөө бол олон улсын жишигт нийцсэн энэ нэрийг л юу гэж өөрчлөх нь үл хамаараад ийм цаад зорилго нь ойлгомжтой ийм эдийн засгийн ангилал байгаа. Зүгээр энэ эдийн засгийн ангиллын ач холбогдол нь бол илүү хувийн хэвшилд бид нар дэмжих зорилготой. Төрийн албан хаагчдын орон тоог жишээ нь саяын түрүүний авсан жишээнээс харах юм бол хүүхэд хамгаалал гэдэг дээр жишээ нь сэтгэл зүйч гэдэг албан тушаалыг бид бий болгоод тэрийг ингээд байнгын ингээд орон тоо бий болгоод ингээд төрийн албыг нэмэх биш шаардлагатай үе болгонд нь энийгээ ингээд гуравдагч этгээдээр гүйцэтгүүлээд ингээд явах нь илүү үр ашигтай байна гэдгийг бол ийм зүйл харж байгаа юм.

Зүгээр нэг анхаарууштай зүйл нь бол энэ эдийн засгийн ангиллаас бол гарч байгаа зардлуудыг илүү тодорхой болгох. Гэхдээ энэ эдийн засгийн ангиллаас гарч байгаа гүйлгээний тоог гээд харах юм бол зөвхөн юу гэдэг юм хүүхэд хамгаалал дээр гэхэд бараг жилдээ дунджаар бол 30 мянгаас 100 мянга орчим гүйлгээ гарч байгаа ийм тохиолдолд бол илүү энийг хувь хүний хамааралгүйгээр цахим байдлаар бол энийг шийдвэрлэх, хяналт тавих, ийм шаардлагатай байна гэдэг зүйл харагдаж байгаа юм аа.

Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Д.Батбаяр: Сангийн яамны төлөөлөлд баярлалаа.

Тэгээд өнөөдрийн хуралд ахиад хүрэлцэн ирсэн дараагийн байгууллагыг танилцуулах ёстой. Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Баясгалан хүрэлцэн ирсэн байна. тэгээд өнөөдрийн хуралдаан дээр энэ энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн төлөөлөл ирсэн байгаа. Илтгэл тавихгүй. Та бүхэн гишүүд маань асуултуудаа тодруулж асууж болно. Мөн аудитын байгууллагын төлөөлөл ирсэн байгаад байгаа. Бид нар яагаад өдийд өнөөдөр ер нь зохион байгуулж байгаа вэ гэхээр өнгөрсөн 7 хоногт аудитын байгууллага өнгөрсөн 2024 оны төсвийн гүйцэтгэл дээр дүгнэлт гаргасан тэгээд тайлан гаргасан учраас тэр тайланг хүлээгээд засагт өргөн барих юм уу Улсын Их Хуралд өргөн барихыг хүлээж байсан. Нэгэнт өргөн баригдсан учраас яг энэ бид нарын өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор та бүхэнд дахиад хэлэх мэдээлэл байгаа юу? Тийм Аудитын байгууллагаас. 3 номерын микрофоныг нээе.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал гэдэгт маань яг юу орох ёстой юм бэ гэхээр байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа үйлчилгээнд төлөх зардал буюу энэ ангилалд тусгайлан заагдаагүй боловч хууль тогтоомж эрх зүйн бусад шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээний зардлыг бусдаар гүйцэтгэх ажил, үйлчилгээнд төлөвлөж, зарцуулж байгаа.

Төрийн аудитын байгууллага, төсвийн тухай хуульд заасны дагуу 6 дугаар сарын 10-нд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газар 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж дүгнэлтээ Улсын Их Хурал, Засгийн газар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байгаа. Би та бүхэнд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд урсгал зардалтай холбоотой ямар асуудлуудыг төрийн аудитын байгууллагаас дүгнэлт гаргасан бэ гэдэг талаар товч танилцуулахаар гэж бодож байна. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн урсгал

зардлын аудитдаа бид урсгал зардлыг сонгуулийн жилийг дагнасан амлалтын шинжтэй зардлуудыг төсвийн жилийн дундуур нэмж төлөвлөн тодотголоор нэмэгдүүлж баталсан нь Төсвийн тухай хуулийн төсвийн үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой байх зарчмуудад нийцэхгүй байна гэж ингэж дүгнэсэн байгаа. Ер нь бол урсгал зардал 2024 онд нийт зарлага цэвэр зээлийн 73.6 хувийг бол урсгал зардал эзэлж байгаа. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийг үнэн зөв бодитой төлөвлөөгүйгээс улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх урсгал зардлын хэмжээ тэлж, улсын хөгжлийн бүтээн байгуулалт дэд бүтцийн хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт санхүүжилтийн гүйцэтгэл хангалтгүй байна гэж ингэж үзсэн.

Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 245 дугаар тогтоолоор Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн хязгаарыг баталж өгсөн. Төсвийн ерөнхийлөн захирагчид бол нийт хязгаараасаа 11 их наяд төгрөгөөр давуулж төсвийн төслийг үндэслэлгүй төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Үүнийг Сангийн яам бол 6.5 их наяд төгрөгөөр хянаж төсвийн төслийг бол батлуулсан. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын ирүүлсэн урсгал зардлаас 3.6 их наяд төгрөгөөр бууруулж баталсан боловч төсвийн хязгаарыг 2.8 их наяд төгрөгөөр давуулж баталсан байгаа. Нийт зарлага ба цэвэр зээлд эзэлж байгаа урсгал зардлын төсөв жил бүр өсөж байгаа нь улсын хөгжлийн болон урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан хөгжлийн бүтээн байгуулалт, дэд бүтцийг нэмэгдүүлэхэд чиглэхгүй байгаа нь үр ашгаа бууруулж байна гэсэн. Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг үндсэн үйл ажиллагааны төлбөрөөс бусад төлбөр арга хэмжээг багцлан төлөвлөж эдийн засгийн ангиллаас гардаг зардлуудад зарцуулж нийт дүнгээр тайлагнаж байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод хариуцлагатай байдал төсвийн сахилга батыг алдагдуулж байгаа гэж ингэж бид аудитын тайлангаараа гаргаж ирсэн. Улсын төсвийн цалин, НДШ-ээс бусад урсгал зардал сүүлийн 3 жилд огцом өсөхөд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 1.8 дахин, бараа үйлчилгээний бусад зардал 3.4 дахин нэмэгдсэнээс голлон шалтгаалсан.

Дээрх зардлуудаас эдийн засгийн ангиллаар хамгийн өндөр төсөв болон өсөлттэй төсвийн ерөнхийлөн захирагч нарыг бид тайландаа оруулж өгсөн байгаа. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйл үйлчилгээний төлбөр хураамж хамгийн өндөр төлөвлөгдсөн төсвийн ерөнхийлөн захирагч бол Боловсролын сайд 139 тэрбум, ХЗДХ-ийн сайд 101.6 тэрбум гэх мэтчилэн сайдуудын өндөр төлөвлөгдсөн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлууд байна.

Улсын төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн үнэн зөв тайлагнасан боловч улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төлөвлөлт хангалтгүй байгаагаас батлагдсан төсөвт сар бүр хуваарийн өөрчлөлт хийж төсвийг зориулалт бусаар зарцуулах төлөвлөгдөөгүй зардлуудыг санхүүжүүлэх зөрчил буурахгүй байна гэж ингэж дүгнэсэн.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагч нарын бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа, ажил үйлчилгээний төлбөр хураамжуудын ангиллуудыг эдийн засгийн ангиллуудаас хамгийн өндөр хуваарилагддаг нь

бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж байгаа. Энэ төлбөр хураамж жил бүр өсөх хандлагатай байна аа.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын үндсэн үйл ажиллагааны зардлын зарим арга хэмжээнүүдийн зардал тус зардлуудад төлөвлөх шаардлагагүй мөн олон эдийн засгийн ангилалд хуваарилах шаардлагатай тодорхой арга хэмжээнүүдийг бол төлөвлөсөн байгаа.

Дараагийн асуудалд нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын үндсэн үйл ажиллагааны зардлын зарим арга хэмжээний зардалд эдийн засгийн ангиллаар хянагдах боломжтой зардлуудад төлөвлөж болох зардлуудыг төлөвлөөд байгаа нь энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудын нэлээдгүй зөрчлүүд нь эндээс гарч байгаа.

Бид нар энэ байгаа эдийн засгийн ангиллыг тодорхой болгох зайлшгүй шаардлага байгаа. Энэ дээр Засгийн газар тогтоол гарсан. Сая Санжаадорж дарга Засгийн газар тогтоолуудаар бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлын төлөвлөлт дотор нь байгаа ангиллуудын талаар хийж байгаа ажлуудаа бас танилцууллаа. Бусдаар гүйцэтгүүлэх жил үйлчилгээний төлбөр хураамж бүлгийн зардлын эдийн засгийн ангиллын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг үйлчилгээний төлбөр хураамжийн 91.8 хувийг, бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд бусад зардлын ангиллын 96 хувийг бүлэг доторх зардал эзэлж байгаа. Аудитын байгууллагаас нийт улсын төсвийн 20 төсөв захирагч нарын бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний хураамж, бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас бусад зардалд 80-аас 100 хувийн зардлыг бол хуваарилж ингэж зарцуулсан байгааг бид нар тайландаа төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр нь гаргаж өгсөн байгаа. Тэгэхээр энэ зардлыг бол гарч байгаа гүйцэтгэлийг нарийвчлан хянах үнэлэх боломжгүй төсвийн ил тод байдлыг хангагдахгүй байна гэж ингэж тайландаа бүлэг болгож оруулсан.

Тайлангууд дээр төсвийн ерөнхийлөн захирагчдын бүлэг бүр дээр энэ урсгал зардалтай холбоотой гарсан өөрчлөлт зөрчлүүдийг бол оруулж өгсөн байгаа. Өмнөх оноос бол одоо энэ жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил нэмэгдсэн байгаа гэдгийг тайландаа бид оруулж өгсөн байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Батбаяр: Баярлалаа. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны урсгал зардлын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зарцуулалтын талаар Сангийн яам болон Аудитын Үндэсний аудитын газрын танилцуулга явж дууслаа.

Одоо эдгээр байгууллагуудтай болон бусад байгууллагуудтай холбоотой албан тушаалтнуудаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Цогтбаатар гишүүнээр тасалчихъя. Батжаргал гишүүн асуулт асууя. Ирцээрээ ахиад эрэмбэлэгдсэн байна. Цогтбаатар Даваагийн Цогтбаатар гишүүний микрофоныг нээе ээ.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Миний бодлоор болдог бол энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар энэ зардлуудыг бүүр яг дэлгэрэнгүйгээр нь ирүүлж байвал их сайн болох гээд байгаа юм. Одоо бид нар зүгээр ингээд харахаар баахан бүлэглэхсэн тэгээд энэ үндсэн үйл ажиллагааны зардал гэдэг

ангиллын нь харахаар 80, 10, 10 гэдэг дээр хамгийн том том зардлууд явчхаад энэ дотор нь юу орж ямар үр дүнд хүрээд байгаа гэдгийг бид нар хэмжиж чадахгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энийг аудит юм уу эсвэл Сангийн яам яг дэлгэрэнгүйгээр нь гарч байгаа төгрөг болгоноор нь ирүүлчих юм бол бид нар энэ гарч байгаа зардлаар ямар ажил хийгээд ямар үр дүнд хүрсэн бэ гэдэг дээрээс уг нь шүүмжлэл өрнүүлээд энэ нь Монгол Улсад хэрэг болоод байна. Энэ яаманд хэрэг болоод байна. Энэ асуудлууд нь Монгол Улсад үнэхээр хэрэг алга. Өнгөрсөн хугацаанд нэг хэдэн төгрөг зарлагадаад өнгөрсөн энийг энэ чигт нь орхиод дараагийнхаа өөр юманд анхаарлаа хандуулаад өөр үр ашигтай зүйлд мөнгөө үрээд явах чиглэлд байвал их сайн байна гэж хараад байна. Энийг Сангийн яам гаргаж өгөх үү эсвэл аудит гаргаж өгөх үү? Бид нар дээр би нэг жил гаруй болж байна. Нэг төсөвтэй ноцолдоод 2, 3 сар ноцолдох гэж оролдсон. Тэгээд одоо яг нөгөө хамгийн тийм нөгөө дэлгэрэнгүй задаргааг ерөөсөө харж чадахгүй байгаа. Хууль зүйн яам яг ямар, ямар байшинд, ямар ямар мөнгө гаргаад цахилгаан дулаантай холбоотой гэдэг юм уу байр ашиглалттай холбоотой гэдэг юм уу цалин хөлстэй холбоотой гэдэг юм уу, нэмэлт урамшуулал, цалинтай холбоотой гэдэг юм уу бүх зардлуудыг харж чадахгүй өнөөдрийг хүрчхээд байгаа юм.

Одоо энэчээнээс ингээд харахаар бид нар өм цөм өсчихсөн зардлууд байгаад байна. Тэгээд эд нар дээр тодруулга авъя гэхээр болдог ч юм уу, болдоггүй ч юм уу? Жишээлэхэд энэ Сангийн яам дээр харуул хамгаалалттай холбоотой зардал 1 тэрбум 700 сая төгрөг гарчхаад байх шиг байгаа юм. Өмнөх жилүүдэд 1 тэрбум 200, 300 гарч байсан юм. Яг энэ жил энэ 2024 оны дүгнэлт дээр яагаад 300, 400 сая төгрөгөөр нэмэгдээд гараад явчхав. Одоо энэ нөгөө тойм дүнгүүдээ л харах гээд байгаа юм. Тэгээд энэ хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал гээд бүүр 7 тэрбумаар цоо шинээр гараад ирж байгаа. Энэ дээр одоо юун дээр нь гараад байгаа гэдгийг мэдэхгүй байгаа учраас одоо ингээд тоо болгоноор нь асуух л хэрэг гарчхаад байгаа юм. Энэ бол зөвхөн жишээ.

Тэгэхээр энэ яамдууд дээр гарч байгаа энэ зардлуудыг уг нь яг томоос нь жижиг хүртэл нь тавьж байгаа. Бид нар энэ зардлаар ийм үр дүнд хүрчихсэн гэдэг юмаа хараад яривал надад бол илүү үр дүнтэй юм шиг санагдах гээд байна. Их л ерөнхий асуулт асуух гээд байна. Нөгөө мэдээлэл харьцангуй хязгаарлагдмал ирээд байгаа учраас.

Д.Батбаяр: Сангийн яамны 5 дугаар микрофоныг нээе.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Яах вэ яг тусгайлан хэлэх юм бол Сангийн яаман дээр байгаа байр ашиглалтын зардал тэрбум 200 байж байгаад тэрбум 700 болдог нь бол манайх гаалийн тэр жишээ байх тиймээ? Тэгэхдээ зүгээр яах вэ санаа нь гаалийн байгууллага болон татварын байгууллагынхан Улаанбаатар хотод байгаа. Харуул хамгаалалт гээд үндсэн орон тоон дээр явж байсан тэр орон тоонуудаа цомхотгоод оронд нь мэргэжлийн тийм байгууллагаас үйлчилгээ авдаг болох тийм одоо зүйлийг бид нар нэвтрүүлсэн юм.

Бусад яамдуудаа жаахан оройлох гэх юм уу даа. Тэгэхээр нөгөө талдаа бол орон тоо нь хасагдаад, цалин нь хасагдаад тэгээд мөргөчхөж байгаа гэсэн үг. Тэгээд жил болгон бид нар ингээд бага багаар нь нэмэгдүүлээд эхний ээлжид Улаанбаатар

хотод байгаа 6 дүүрэг тэгээд цаашдаа бол Улаанбаатар хотоос гадна байгаа 3 дүүргүүдээ нэмээд явах ийм төлөвлөгөөтэй бол ингээд ажиллаад явж байгаа.

Хэрвээ энэ маань бүтэмжтэй байх юм цаашаа явна зүгээр. Ер нь зүгээр мэдээллийн хувьд бол энийг ингээд олж харахад хүнд байна гэдэг зүйл ярьж байна. Яах вэ Төсвийн тухай хуулийн хавсралт дээр бол бид нар зөвхөн эдийн засгийн ангиллаар нь харуулчихаад байгаа юм.

Дээрээс нь төсвийн ерөнхийлөн захирагч дээр нь харуулчихаад байгаа юм. Тэгэхээр нөгөө дунд талын нөгөө зориулалтууд маань тусдаа харагдчихлаар ингээд гишүүдийн хувьд бол цаасан дээрээс харахаар тэрийгээ нөгөө хооронд нь марж хийж гарч чадахгүй л байгаад байх шиг байна л даа.

Хэрэвзээ юу гэдэг юм энийг ингээд бүүр уртаар нь ингээд тавих юм бол маш урт зүйл болоод тэр хэвлэх тэр цаасан дээр боломжгүй болох байх л даа. Их хурлаас хэвлэж байгаа дээр. Тэгэхлээр энэ жилийн хувьд бол бид нар 2026 оны төсвийн төслийг өргөн барихдаа бол файлаар нь яг энийг ингэж бүүр томоор нь дэлгэж тавьж байгаад тэгээд гишүүдийн хувьд бол энийг өмнөх онуудтай нь харьцуулах боломжтой байхаар тийм байдлаар яваад тэрийгээ гишүүдийн нөгөө и мэйлээр нь хүргүүлээд тэгээд анализ хийх боломжтой байхаар явуулъя гэж тооцоод ингээд төлөвлөөд явж байгаа. Тэгэх юм бол илүү ойлгомжтой болчихно. Ерөнхийлөн захирагч нараар нь нэг бүгдийг нь базаж хараад жишээ нь Хууль зүйн сайдын багцын бусдаар гүйцэтгүүлсэн нийтдээ хэд байна гэдгийг харж болохоор. Тэгээд тэндээсээ дахиад байгууллага болгоноор нь харж болохоор ч гэдэг юм уу тийм юун дээр мэдээлэл дутуу байна гэдэг дээр тэгэхлээр таны шүүмжийг хүлээж авч байна.

Д.Батбаяр: Цогтбаатар гишүүн тодруулъя. Нэг минут өгье.

Да.Цогтбаатар: Энийг юу гэдэг юм илүү ажил хэрэгч байдлаар гэх юм уу ярих юм бол датаны том жижиг, урт богиноос бол би ерөөсөө 1 их санаа зовохгүй байгаа юм. Одоо юу гэдэг юм Хууль зүйн яам гэх юм бол Хууль зүйн яамны харьяа байгууллага хэдэн байгууллага байгаа юм дахиад л 1, 1-ээр л шийднэ гээд л. Тэгээд тэрэнтэйгээ холбоотой гарч байгаа жишээлэхэд энэ урсгал зардлынхаа задаргаануудыг өгчих юм бол тэрэн дээр бид нар ажиллахад бол нэг их тийм түүртээд байх юм бол миний хувьд бол жишээлэхэд юу ч байхгүй. Зүгээр задгай файл нь ирэхгүй байгаа дээр л ингээд асуудал үүсээд байгаа асуудал үүсээд байгаа юм. Одоо жишээлэхэд та сая өөрөө жишээ аваад ярилаа шүү дээ. Бид нар ингээд харуул хамгаалалтын ажлуудыг мэргэжлийн компаниудад өгөөд тэрийгээ энэ дээр нь ингээд бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээний зардал болгож оруулж ирээд байгаа юм гээд.

Жишээлэхэд хэдэн орон тоо яг жишээлэхэд цомхотгож чадаад орон тооны цомхотголоор бид нар хэдэн орон тоог хэмнээд, хэдэн төсвийг хэмнээд бусдаар гүйцэтгүүлж байгаа.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

М.Санжаадорж: Гишүүний хэлж байгаа санал шүүмжтэй санал нэг байна. Тэгээд энэ жилээс бол түрүүний хэлсэнчлэн мэдээлэл хүргүүлж ажиллая. Ер нь зүгээр төсөвтэй холбоотойгоор бол төсвийн энэ нөгөө мэдээллүүд маань яг ингээд

ухаад үзэх юм бол түрүүн 100 хэдэн мянган гүйлгээ гэдэг шиг 4300 орчим төсвийн байгууллага байгаа. Тэгээд төсвийн ерөнхийлөн захирагч гэх юм бол 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот, тэгээд 20 сайд, Ерөнхий сайдыг оруулаад 21 сайд тэгээд Улсын Их Хурлын өмнө тайлагнадаг болон шүүх байгууллагууд гээд ингээд тооцохлоор 57, 58, 59 төсвийн Ерөнхийлөн захирагч болчихоод байгаа юм. Тэгээд энэ бүх байгууллагууд ингээд байгууллага болгоноор нь харах илүү анализ хийх гэдэг юун дээр бол Сангийн яамны хувьд бол бас энийг тайлбарлаж илүү нээлттэй мэдээлэл цаашдаа өгч явъя гэсэн ийм дүгнэлт хийж байна аа. Баярлалаа.

Д.Батбаяр: Ахиад Сангийн яамнаас ахиад нэмээд асууя. Нөгөө хөтөлбөр төслийн урсгал зардал гээд 7 тэрбум гээд асуусан мөн орон тоотой холбоотой асуулт асуулаа шүү дээ тиймээ. Товч бөгөөд тодорхой та хариулчихыг хичээгээрэй. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн сайдын багц дээр байгаа бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг зориулалт талаас нь асууж байна. Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал бол Монголын талын нөгөө хариуцах зардал байгаад байгаа юм. Одоо жишээ нь мянганы сорилын сан дээр нөгөө тусламжаараа тэдний талаас мөнгө нь ороод ирнэ. Монгол тал бас манайхаас одоо дундын контрибушн хийж паундс гэх юм уу даа. Монгол тал бол жишээ нь оффисын зардлаа хариуцаж байдаг гэдэг ч юм уу. Тэр тухайн гэрээнээсээ шалтгаалж Монголын талын зардал байдаг. Тэр гэрээнийх нь дагуу улсын төсвөөс төлж байгаа мөнгө гэсэн үг. Нөгөө тал нь бол одоо зээлийн талаасаа гэж байгаа.

Тийм. Тэр бол яах вэ гэрээгээрээ л орж ирчхээд байгаа л зүйл. Тийм гадаад зээлийн ашиглалт нэмэгдээд л байх юм бол тэр зардал нэмэгдээд байна. Нөгөө талдаа манай гэрээнүүд яаж хийгдэж байгаагаасаа л шалтгаалж байгаа гэсэн үг.

Д.Батбаяр: Баярлалаа. Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр урсгал төсөвтэй холбоотой, тэр тусмаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээтэй холбоотой мэдээллээ дагнаж нэг тусад нь яриад ойлголт юмнуудаа нэгтгэх тухай л асуудал байна л гэж би ойлгоод байна шүү дээ. Ер нь 2025 оны төсөв хэлэлцэх явцад хэдүүлээ нэлээн маргаан дэгдээсэн юм чинь энэ шүү дээ. Энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ сүүлийн дараалсан он жилүүдэд нэлээн огцом нэмэгдсэн байна. Энүүнийг бууруулах ёстой гэдэг ийм юмнууд нэлээн ярьцгаасан.

Тэгэхээр зүгээр би эдийн засгийн ангилал талаасаа зөв л байдаг байгаа даа л гэж л бодоод байна л даа. Салбаруудын үндсэн үйл ажиллагаа байж болохоор зүйлүүд байгаад байгаа байхгүй юу дийлэнх нь дотуур байр, МСҮТ-ийн суралцагчдын хувьсах зардал, мал эмнэлгийн ажил үйлчилгээ эд нар гээд ерөөсөө энэ чинь тухайн салбар салбар дээр баримтлагддаг үндсэн үйл ажиллагаанууд энд орчихоод яваад байгаа юм. Тэгээд энийгээ хэдүүлээ энүүгээр нь нэршээд ангиллаараа яваад байж болох юм уу? Нэг том дүн харагдуулаад нийгмийг талцуулаад үймүүлээд байх юм уу, эс үгүй бол нэг ийм нийтлэг нэршил дээр хэдүүлээ юм авч гардаг нэг тийм жамтай л даа.

Төсөв дээр бусад зардал гэж хийж байгаад хэдүүлээ жоохон юм аваад үлдчихдэг байсан. Одоо бол би энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ рүү гүйлгэдэг нэг ийм санаархал байгаад байгаа юм уу гэмээр юм байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ талынхаа юмыг их тодорхой болгосон нь дээр байх аа. Би бол тэр талаас нь Сангийн яамнаасаа тодруулмаар байна.

Хоёрдугаарт энэ бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээ бол яах аргагүй хувийн хэвшил гэдэг юм уу мэргэжлийн байгууллага гэдэг юм уу энэ байгууллагуудаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээнүүд дийлэнх нь явчхаж байгаа. Хувийн мал эмнэлгийн байгууллагууд ч гэдэг юм уу ингээд.

Тийм учраас энэ талаасаа харахаар эдийн засгийг тодорхой хэмжээнд идэвхжүүлж, цаашид энэ чиглэлээрх төсөвлөлт нь ч тэр, гүйцэтгэл нь ч тэр буурахгүй өснө. Ажил үйлчилгээний цар хүрээ өргөжиж байгаа юм бол нэмэгдэнэ шүү дээ энэ чинь. Бид хэд энд мянга буулгая гэж орилоод ямар ч асуудал байхгүй шүү дээ. Тийм учраас ангиллаа зөв болгох тухай л ойлголт байгаа. Харин зүгээр дотор нь нэлээн нарийсгаад үзэх юм бол жоохон жоохон бялуурсан юмнууд байгаад байгаа юм биш биз дээ. Эрдэм судалгааны хүрээлэн элдэв бусын юмгүй яамдууд чинь энэ эрдэм судлал судалгааны ажил дээр ер нь ямар том том мөнгөнүүд тавиад гөвөөд байгаа юм бэ?

Дээр нь энэ мэдээлэл сурталчилгааны чиглэлийн юман дээрээ хөөрхөн юмнууд тавиад яваад байгаа юм биш үү? Энэ юмнуудаа ер нь цаашид яаж хэдүүлээ зөв болгох юм бэ? Ер нь нэгж ажил үйлчилгээнд ноогдох зардлын тухай асуудал тэгээд тэрний.

Д.Батбаяр: Сангийн яам. 5 дахь микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Батжаргал гишүүний асуултад хариульа аа.

Батжаргал гишүүний ярьж байгаа зүйлтэй санал нэг байна. Сангийн яам бол яг энэ зүг рүү яваад байгаа.

Гуравдагч этгээд буюу илүү төрийн байгууллагаас нэг төрийн байгууллагаас нөгөө төрийн байгууллагад зарцуулдаг эсвэл төрийн байгууллага өөрийнхөө үндсэн үйл ажиллагаандаа зарцуулж байгаа тийм зардлуудыг бол бид нар цэвэрлэх гээд явж байгаа.

Яг таны түрүүний хэлдэгчлэн одоо ингээд жишээ болгоод хэлэхэд бол хамгийн том зардал эзэлж байгаа нь жишээ нь авто замтай холбоотой зардал байна. Хот тохижилттой холбоотой зардал байна. Тэгтэл нөгөө орон нутагт энэ маань өөрөө аж ахуйн тооцоотой байгууллагад өгч байгаа бид нар тэр хүмүүсээр тарифаар нь гүйцэтгүүлж байгаа. Тэгэхээр энэ зөв үү буруу юу гэдэг дээр бид нар дүгнэлт гаргах гээд ажиллаж байгаа.

Хувийн хэвшил ТББ нь бол асуудалгүй болчхож байгаа юм. Түрүүний хэлж байгаа жишээ нь дотуур байрны үйлчилгээ дээр бол бид дотуур байрыг бол нөгөө илүү нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлаар нь санхүүжүүлэх гээд үзээд байгаа юм. Тэгэхдээ бодит зүйл дээр бол яаж байна гэхлээр боловсрол, эрүүл мэндийг бол бид нар илүү төрөөс гаргах тарифаар санхүүжилт, гүйцэтгэлээр санхүүжилт гэж тооцсон боловч тэр хараахан тэр юундаа хүрч чадахгүй байгаад байгаа юм. Онолын хувьд бол яах вэ гэхлээр одоо жишээ нь яг эмнэлэг шиг эмнэлгийг бид нар илүү их

гүйцэтгэлээр нь санхүүжүүлээд эхэлчих юм бол энэ өөрөө бусдаар гүйцэтгүүлсэн ажил гээд түрүүний нөгөө аж ахуйн тооцоон дээр ажиллаж байгаа тэр хот тохижилт шиг болоод явчих юм бол эдийн засгийн ангиллын хувьд зөв болоод явчхаж байгаа юм.

Түрүүний тэр нөгөө шинжлэх ухаантай холбоотой ШУТС гэдэг дээр бусдаар гүйцэтгүүлсэн гэхээд байгаа юм. Тэнд ямар агуулга яваад байна гэхээр манай төрийн хүрээлэнгүүд тэгээд төрийн өмчит их, дээд, сургуулиуд тэгээд бусад хувийн өмчит эрдэмтэд хувиараа төсөл бичээд тэр төсөл нь хэрэгтэй, шаардлагатай байна гэх юм бол тэр үндсэн чиглэлд захиалгын чиглэлд багтсан бол тэндээ мөнгө өгөөд ингээд бусдаар гүйцэтгүүлж төсөл бичүүлээд төсөл нь буцаж ирээд цаас болоод архивлагдаад одоо тэр төсөл нь хэрэгжиж байгаа үгүй нь дараачийн асуудал болж байгаа байх. Ямар ч байсан нэг ийм процесс яваад байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл юу гэдэг юм бас нөгөө талдаа энэ маань бол төрийн өмчит хүрээлэнгүүдийнх нь бас нэг төрлийн л тийм нэг санхүүжилт болчихоод байгаа юм. Тэгэхээр заавал тэгж өрсөлдөөнөөр ингэж явж байгаа зардал байх юм бол энэ өөрөө бусдаар гүйцэтгүүлсэн биш байна гэж харчхаж болохоор байгаад байгаа юм.

Тэгээд үүнтэй холбоотойгоор бол төсвийн тодотгол дээр ШУТС дээр бид нар тодорхой арга хэмжээ авах гээд бол оруулж ирж байгаа. Ер нь товчхондоо бол одоо яг төрөөс заавал ингээд улсын төсвөөс санхүүжилт аваад явж байгаа. ШУТС маань эргэлтийн хөрөнгө гэж байхгүй тэнд. Менежмент нь бол дэндүү хаалттай учраас хувийн хэвшил орж ирэхгүй тэнд. Тэгээд ямар нэгэн байдлаар бол татвар хураамжаар эргэлтийн сан байхгүй. Ийм сангуудыг ер нь нэг бол зүгээр татан буулгаад тэгээд энэ чинь өөрөө болж өгвөл зүгээр тэр байгууллага дээр очоод нөгөө талын санхүүжилт болчихоод байгаа юм чинь байгууллага дээр санхүүжилтийг нь тавиад явбал бараг зөв юм биш үү. Нэг бол хувийн хэвшилтэй хамтарсан байдлаар илүү менежментийг нь бол либерал болгоод сан маань өөрөө бие даагаад бол хөрөнгө босгох боломжтой байгаад мөн одоо тэр төсөл шалгаруулж байгаа процесс маань бол хэн ч гомдож санахгүйгээр төрийн өмчит тэр хүрээлэнгүүдийнх нь толгойг илээд өгдөг биш жинхэнэ юу гэдэг юм Монгол Улсад хэрэгтэй тийм төслүүдээ тэргүүлэх чиглэлийн төслүүдээ шалгаруулдаг ийм болоод явбал болох гээд байна гэдэг ийм зүйл ярьж байгаа.

Тэгэхээр яг таны хэлдгээр кэйс болгон дээр өөр өөр агуулга гарч ирчхээд байгаа юм. Тэгэхлээр бид нар юугаа барих ёстой вэ гэхлээр яг түрүүний GFS-ийн мануалаа барьж байгаад нөгөө гарын авлага гаалиа барьж байгаад тэгээд тэрнийх нь дагуу л одоо яг энэ орно, орохгүй гэдэг байдлаар бол ялгаад тэгээд бууруулахыг нь бууруулаад тэгээд үндсэн үйл ажиллагаа дээр нь тавигдах ёстой тэр шатахуун бол шатахууныг нь шатахуун дээр нь төлөвлөө өө л гэж байгаа тийм л зүйл харагдаж байгаа.

Д.Батбаяр: Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Ийм 1 ерөнхий нэршилтэй том тоо агуулчхаад байгаа энэ зүйлүүд нийгмийн сэтгэл зүйд хар дагуулдаг, шүүмжлэл дагуулдаг. Тэгээд тэрнийхээ цаана нэг тиймэрхүү зүйлүүдийн илэрхийллүүд нуугдаад явдаг ийм л зүйл л дээ. Тэгэхээр энэнээсээ хэдүүлээ гарчихмаар байгаа юм. Тийм учраас би ер нь болж өгвөл энэ эдийн засгийн ангиллаа илүү жоохон нарийсгаж зөв болгох талын юм илүү бодвол дээр юм биш байгаа даа гэж. Яг л яам яаман дээр очихоор үндсэн

үйл ажиллагаатай нь холбоотой л том зардлууд энд бөөнөөрөө орж ирчхээд байгаад байгаа юм.

Спорт ярихаар зэрэг өнөө олимпод явдаг хэдэн тамирчдаа дэмжихээс авхуулаад юмнууд нь орчхоод байдаг ч гэдэг юм уу ийм юмнууд л байгаад байгаа байх. Нөгөө талд нэг зүйл байна. Энэ дүгнэлт юмнуудыг хэдүүлээ нэг жоохон зөв мөв хиймээр анзаармаар юмнууд байна. Би аудитыг энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ өссөн талаасаа биш.

Д.Батбаяр: Батжаргал гишүүн гүйцээж асууя, тодруулъя.

Ж.Батжаргал: Өгөөж үр дүнгүй юмнууд тусгаж оруулаад гарчихсан дүн л хэрэгтэй байна надад.

Хоёрдугаарт сонгууль 6 сард болсон төсвийн тодотгол би энэ чинь одоо 7 сарын сүүлч, 8 сарын эхээр хийсэн шиг санаад байх юм.

Тэгээд яахаараа сонгуулийн амлалтуудыг төсвийн тодотголд оруулдаг билээ хүүхээ.

Тэрүүгээр чинь бид 2024-2028 оны том төслүүдийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг 2025 оны 1 сарын 1-ээс өмнө хангах чиглэлтэй холбоотой асуудлуудыг төсвийн тодотголд тусгаж оруулсан. Та хэд юмнуудаа жоохон нухацтай хандаж улс төрийн дүгнэлтгүй дүгнэлт гаргана шүү. Энэ эргээд нийгэмд хүрдэг эд шүү. Урагшлаад байгаа наад 14 мега төслийн чинь бэлтгэлийг хангуулах, ТЭЗҮ, зураг төсвийнх нь асуудлыг шийдэх гээд нэлээн томоохон томоохон зориг гаргаж хөрөнгө тавьсан.

Д.Батбаяр: 3 номерын микрофон, аудитын газар. Сонгуультай холбоотой, улс төртэй холбоотой гэсэн дүгнэлт гаргасан байгаа. Тэн дээрээ тайлбарлах.

Ц.Наранчимэг: Энэ аудитын баг аудит хийгээд явж байхдаа бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг бол сая яг Батжаргал гишүүний хэлсэнтэй адилхан дүгнэлтийг гаргасан. бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээнд байгаа зардлууд маань төлөвлөх боломжтой ийм зардлуудыг энэ бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээнд төлөвлөж зараад тэгээд зарим тохиолдолд зардал хооронд шилжүүлэн зарж байгаа нь болохгүй байна аа. Энэнийхээ бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлынхаа энэ ангиллыг тодорхой болгох зөвлөмжийг бол Сангийн сайдад өгсөн байгаа.

Сонгуулийн шинжтэй амлалтын гэдэг нь сонгуулийн үед сонгуулийн дараа хуульд заагдсан хөтөлбөрт орсон энэ зардлууд нэмэгдээд батлагдаад байгаа нь урсгал зардлын шинжтэй энэ хязгаарыг нэмэгдүүлсэн байна гэдэг үүднээс нь.

Д.Батбаяр: Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Юуны өмнө энэ дэд хорооны хурлыг зохион байгуулж байгаад баярлалаа. Өнөөдрийн хурал дээр манай яам Тамгын газрын төсвийн менежерүүд бүгдээрээ хүрэлцэн ирсэн байна. Та бүхэнд бас баярлалаа гэдгээ илэрхийлье.

Тэгээд би энэ дээр нэг дөнгөж саяхан материал авч танилцсан учраас нэлээн ч тодруулж байж асуухаар юмнууд нэлээдгүй байна. Тэрийг дараа дараагийн хурлууд дээр ярья гэж бодож байна. Өнөөдөр би нэг 2 асуултыг, 2, 3 асуултыг энэ аудитаас болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуучихъя гэж ингэж бодож байна. Ер нь бол энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ шаардлагатай юу, байгууллагад шаардлагатай юу шаардлагатай. Олон улсын ийм төсвийн ангилал стандарт байна уу байгаа. Энэ дагуу явж байна уу явж байгаа. Тэгэхдээ сүүлийн энэ 2, 3 жилийн өсөлтийг харахад нэг жилийн 25 хувийн өсөлттэй яваад байна. Энэ нь зөв үү буруу юу гэдэг дээр асуудал эргэж харж үзэх нь зөв байх гэж ингэж бодож байна. Ингээд би 2, 3 асуултыг Аудит болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя.

Нэгдүгээрт нь сая аудитын танилцуулгад энэ төсвийн ангиллын бас бид нар эргэж үзэх шаардлагатай байна гэсэн юм ярьчих шиг боллоо. Тэгэхээр төсвийн ангиллыг та нар юу гэж харж байгаа вэ? Одоо байгаа энэ ОУВС-ийн энэ GFS-ийн ангилал чинь нэг олон улсын сүүлд мөрдөж байгаа л ийм ангилал л даа.

Тэгэхээр энэнээс илүү ямар ангиллыг та нар санал болгож байгаа вэ гэсэн 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарт нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ жилдээ бараг энэ чинь 2024 онд бараг 1 их наяд их наяд төгрөг болж байна л даа. Энэний энэ шилэн данстай яг шилэн данс дээр тайлагнаж гарсан хувь нь зардал нь хэд байгаа юм? Шилэн дансанд тавихгүй гээд ингээд жижиглээд жиргээд явчихсан зардлууд нь хэдэн хувь байгаа юм? Тэрэн дээр та нар хийсэн судалгаа тооцоо байна уу гэдэг асуудал.

Гуравдугаарт нь энэ гарч байгаа энэ зардлуудыг ер нь аудитын байгууллага энэ төрийн сангаас гарч байгаа зардлуудыг цахим болгож тухайн цаг үед нь хянадаг больё гэдэг ийм зүйлийг танай байгууллагын дарга сүүлд томилогдоход би энэ хэлэхэд өөрөө ч гэсэн нэг ийм зүйлийг ярьж байсан.

Энэ ажил яг цахимжуулах ажил хэр зэрэг болж байна. Энэ чинь төрийнхөө ажлыг хийж явж байгаад санамсаргүй санаатай мэдэх мэдэхгүйгээсээ болоод янз бүрийн зардал гаргачихдаг. Тэгээд аудит дээр очоод жилийн эцэст очоод бүгдээрээ асуудалд бүгдээрээ нэг л болохгүй хүмүүс төрд ажиллаад байгаа юм шиг нийгэмд буруу мэдээлэл өгөөд байдаг. Зүй нь бол энийг яг энэ төрийн сангаас гүйлгээ гарч байхад аудит хянаад буруу байвал шууд тэрийг нь зогсоодог, гүйлгээг нь зогсоодог ийм хэлбэр рүү л ормоор байгаа юм. Энийг уг нь танай байгууллагын дарга томилогдохдоо энийг ярьж байсан. Тэгээд энэ ажил маань хэр зэрэг явж байна вэ гэсэн ийм 3 асуултыг асууя аа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ төсвийн зардлын ангиллуудыг та нар юу гэж бодож байна аа? Энийг сайжруулахтай холбоотой ямар санал та нарт байгаа вэ гэсэн ийм асуултуудыг асууя. Баярлалаа.

Д.Батбаяр: Гангэрэл та 4 номерын микрофон дээр очоод суучих. 4 номерын микрофоныг нээе.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Гангэрэл. Тэр олон улсын стандарт бол байгаа. Тэгэхээр бол бид нар нэг шинэ дугуй зохиогоод дахиад ингээд байх шаардлага байхгүй гэж бодож байна.

Тийм учраас бол харин хамгийн гол нь тэр дадлын зүйл ангиа энэ олон улсын стандартынхаа дагуу зөв ангилж оруулж байна уу гэдэг дээр Аудитын газар маань илүү нягталж харах шаардлагатай болов уу л гэж тэгж л бодож байна.

Д.Батбаяр: Аудитын ерөнхий газар 3 номер.

Ц.Наранчимэг: Үндэсний аудитын газар, Наранчимэг Заяабал гишүүний асуултад хариулъя.

Зардлын эдийн засгийн ангиллыг сая яг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний хэлсэнтэй яг адил дүгнэлтийг аудитын байгууллагаас гаргаж байгаа. Эдийн засгийн ангилал дээр хуваарилж байгаа зардлуудаа ямар зардал яг энд орох юм гэдгийг нь тодорхой болгоод энийгээ тайлбар мэдээлэлдээ ямар зардал орох вэ? Жишээлбэл бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээнд ТББ, төрийн зарим чиг үүргийг хувийн байгууллагаар гүйцэтгүүлэх, ямар ямар зардал, ямар үндэслэлээр орсон юм бэ гэдгээ тодорхой болгож ил тод болгохгүй бол энэ зардал дээр маш олон болохгүй байгаа жишээлбэл бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас зарим төсвийн ерөнхийлөн захирагч нь хөрөнгө бэлтгэж байгаа мэдээлэл технологийн зардлууд гаргаж байгаа гэх мэтчилэн төсөвлөж болох зардлуудыг гаргаад байгаа учраас аудитын байгууллага яг энэ бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалтай холбоотой эдийн засгийн ангиллын зардлаа тодорхой болгоод.

3 номерын микрофон гүйцээж хариулъя.

Ц.Наранчимэг: Тэр Төрийн сангийн гүйлгээг бид нар бас олон улсын бусад байгууллагуудын аудитын дээд байгууллагуудын туршлагыг судалсан. Жишээлбэл Хятад Улс бол төрийн сангийн гүйлгээг нь аудитын байгууллага нь өдөр тутмын гүйлгээг хянаад сууж байдаг ийм ийм тогтолцоотой байна. Бид нар Сангийн яамны холбогдох удирдлагуудтай уулзсан төрийн сангийн гүйлгээг манай санхүүгийн тайлангийн аудитын пас программтай холбож бодит цагийн хяналтыг хэрэгжүүлэх талаар уулзаад одоо тодорхой ажлуудыг хийж байгаа. Эхлэлүүдийг нь тавьж байгаа. Яг хянаад эхэлж байгааг нь ингэх юм бол бид нарт бас хүн хүч нөөцөө хэмнэнэ, 1 дүгээрт нь.

Хоёрдугаарт нь эрсдэлтэй заавал 6921 байгууллагад аудит хийх шаардлагагүй. Эрсдэлтэй газрууддаа аудит хийж дүгнэлтээ гаргаад эрсдэл багатай газруудаа бол заавал дүгнэлт гаргахгүй байх ийм боломж байна гэдэг судалгааг хийж байгаа. Аудит, репорт, аудит гэсэн ийм шинэ программыг AI дээр.

Д.Батбаяр: 3 номерын микрофон. Гүйцээж хариулъя.

Ц.Наранчимэг: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой тавигдах мэдээллүүдээ бол төсвийн байгууллагууд маань тавьж байгаа. Гэхдээ бид нар ямар шаардлага тавиад байгаа вэ гэхээр зарим гүйлгээг 3 хуваадаг ч юм уу, 4 хуваасан тохиолдолд мэдээллүүдээ тавихгүй байгаа. Тэгэхээр энийг төрийн аудитын байгууллагаас шилэн данс дээр тавих энэ мэдээллийг шууд төрийн сангийн

гүйлгээнээс нь шилэн дансанд нь мэдээлэл тавьдаг ийм нөхцөл боломж байгааг судалж энэ мэдээллийнхээ программыг сайжруулбал зүгээр юм болов уу гэсэн ийм шийдлийг харж байгаа бид нар.

Д.Батбаяр: Заяабал гишүүн тодруулъя. Гишүүний микрофон.

Б.Заяабал: Тэгэхээр аудитаас би яг тодорхой юм асуугаад байгаа шүү дээ. 2024 онд 1 их наяд төгрөг гарчээ. 957 тэрбум төгрөг. Тэрний яг хэдэн хувь нь шилэн дансан дээр тавигдсан бэ? 300 тэрбумын гүйлгээнд тавигдсан юм уу? 957 тэрбум төгрөгийн гүйлгээ нь тэр чигээрээ шилэн дансан дээр тавигдсан юм уу? Танайх Шилэн дансны тухай хуульд хяналт тавих үүрэг чинь танай дээр байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээ тодорхой хариул л даа.

Хоёрдугаарт нь Сангийн яам, Санжаадорж дарга энэ саяын Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон аудитын хэлж байгаа энэ зардлын ангиллуудыг танайх хүлээн зөвшөөрч байгаа юу? Тэрийг хэзээ та нар энийг хүлээж авч ангилах юм гэсэн ийм 2 асуултыг нэмж асууя аа. Ер нь бол энэ төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой Дэд хорооны дарга энэ дээр холбоотой зарим зардлууд дээр зарим төсвийн ерөнхийлөн захирагч дээр тодруулж нэмэлт мэдээлэл авах ийм шаардлагатай юмнууд байгаад байна. Тэрийг албан бичгээр авах ёстой юу? Зарлагын дэд хороогоороо авах ёстой юу тэрийг нэг хариулж өгөөч. Баярлалаа.

Д.Батбаяр: 3 номерын микрофон шилэн дансан дээр байгаа бүртгэл.

Ц.Наранчимэг: Бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас гарсан нийт зардлын 95.7 хувийг нь Шилэн дансанд мэдээлсэн байгаа. Манай тайлан дотор байж байгаа. 5 саяас дээш төгрөгөөр гарсан зардлууд.

Д.Батбаяр: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Гангэрэл 4 номерын микрофон.

Л.Гангэрэл: Энэ сая эрсдэлд суурилсан аудит гэдэг дээр нэмээд нэг юм хэлчихье. Ер нь яах вэ гэхээр сүүлийн үед энэ их нөгөө биг дата, их дата гэсэн тэр ойлголтууд бол сүүлийн 7, 8 жилээс дэлхийд их хүчээ авч байна. Тэгээд зөвхөн төрийн аудит гэлтгүй хувийн хэвшил тэр аудит эрсдэлд суурилсан энэ чиглэл рүү орж байгаа их дата дээр. Тэгэхээр бол энэ Үндэсний аудитын газраас тусгайлан ингээд төсөл хэрэгжүүлээд яг одоо ингээд монголчлохоор биш олон улсын туршлагыг нь яг копидоод сайхан хуулаад, тэгээд тэр цахим, тэр ил шилэн дансных нь юуг нь тухай бүрд нь тэр инстент байдлаар холбож өгөөд тэгээд зайнаас эрсдэлд суурилсан хяналтаа тавиад ирэх юм бол хүн хүч нөөц бололцоо тэгээд одоо бол аудит маань ингээд төрийн байгууллага болгоноор ингэж явж аудит хийгээд байгаа. Тэрнийг арай илүү эрсдэлд суурилсан байдлаар явах юм бол маш их үр дүнтэй болно оо.

Ц.Наранчимэг: Баярлалаа. 6 номерын микрофон Сангийн яам Сангийн яам. Зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ.

П.Бат-Эрдэнэ: Заяабал гишүүний асуултад хариулъя. 2025 оны төсөв батлагдсантай холбоотойгоор Засгийн газарт чиглэл өгөх тухай Их Хурлын 2024 оны 12 сарын 12-ны 52 дугаар тогтоол батлагдсан. Энэ тогтоолын 3.1-ээр бол бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн энэ эдийн засгийн

ангиллыг ер нь авч үзээд цаашдаа яах ийхээ тодорхойлох энэ чиглэлийг Засгийн газарт Их Хурлаас өгсөн. Сангийн яам бол яг энэ төсвийн ангилал болон энэ төсвийн төлөвлөлтийг хариуцдагийн хувьд яг энэ дээр бид тодорхой ажил хийж байгаа.

Манай Санхүүгийн мэдээллийн технологийн төв дээр яг энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж тэгээд бараа үйлчилгээний бусад зардал гэсэн энэ 2 ангиллаар гүйлгээ гарахад цаанаа татварын систем дээр нөгөө татварын нэхэмжлэл нь үүсээд яг тэр дээр гарсан ангиллын дагуу бол ингээд зардлууд нь зарцуулагдаад явдаг.

Тэгээд энэ дээр бол бид гүйлгээнийх нь логиог авч үзээд.

Д.Батбаяр: Сангийн яам гүйцээж хариулъя. 6 номерын микрофоныг нээе.

П.Бат-Эрдэнэ: 2024 оны хувьд 576 мянган гүйлгээг ангилж үзээд эдгээр ангиллаас яг ямар ямар төрлийн үйлчилгээ илүү их давж гарсан байна ямар төрлийн үйлчилгээ эсвэл ажил эндээс хийгддэг юм байна гэдэг дээр бол анализ гэж үзэж байгаа. Энэ ажил тодорхой болсны дараагаар бид төсвийн ангиллаа нэмээд энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ гэдгээ илүү задлах уу эсвэл мөн яг энэ 576 мянган гүйлгээн дотор бусад эдийн засгийн одоо дагаж мөрдөгдөж байгаа эдийн засгийн ангилал руу бас зардлыг нь шилжүүлж тавих иймэрхүү зардлууд байнга гарч ирнэ. Мэдээж тэгэнгүүт энийг яг тухайлсан зөв ангилал руу бас нь төлөвлөх талаар энэ төсвийн ерөнхийлөн захирагч нартайгаа хамтарч ажиллахаар ингэж төлөвлөж ажиллаж байгаа.

Энэ тараагдсан материалын задаргааг Санжаадорж та Сангийн яамнаас гишүүдэд хүргүүлээрэй. Өөр бүр нарийвчилсан байдлаар задалж оруулаад.

Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн мэнд хүргэе. Энэ яг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ гээд ноднин төсвийн үеэр нэлээд их яригдсан асуулт асуудал дагуулсан ийм л ангилал байсан. Тэгээд энэ ангилал дотор сая яах вэ би нэг орж гараад нэг өөр хурал давхцаад ингээд ирлээ. Яг л ангиллуудыг л ярьж байна л даа. Тодорхой бус байна ил тод бус байна, ойлгомжгүй байна, давхацсан байна ч гэдэг юм уу. Тэгэхээр энд асуусан эсэхийг нь би мэдэхгүй. Гэхдээ энд ингээд байгаа шүү дээ. Энэ код бол 21.08 бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд тиймээ нэг ийм ерөнхий ангилал. Тэгсэн мөртөө энэ дотроо 210, 801 нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд ердөө нэг ганцхан үг нэмэгдчихсэн байгаа юм. Нийтлэг гэдэг үг.

Тэгсэн мөртөө энэ нь нөгөө бусад аудит даатгалын үйлчилгээ гээд нөгөө тээврийн хэрэгслийн гээд бусад ангиллуудтайгаа яг агаар нэг ингээд 801, 802, 803 гэж явсан мөртөө яг энэ зөвхөн нийтлэг ажил үйлчилгээ гэдэг нь өөрөө энэ бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний бараг 93.4 хувийг нь эзэлж байгаа. 93.4 хувь. 1.4 их наяд байтал энэ нийтлэг гэдэг нь 1.3 их наяд гээд. Тэгэхээр энэ яг ямар ажил үйлчилгээнүүд юм болоо тиймээ? Түрүүн эсвэл ярьчихсан уу? Энэ дотор би ингээд харахаар энэ слайдуудыг харахаар энэ дотор яг энэ нийтлэг ажил үйлчилгээ нь юу вэ гэдэг нь харагдахгүй л байгаад байна л даа. Тэгээд ингээд харахаар ингээд бусад үйлчилгээнүүдийг нь энэ бусад ангилал дотор нь аминдаа ингээд оруулчихсан байх

шиг л байх шиг байгаа юм. Тэгээд оруулчихсан мөртөө өшөө цаана нь дахиад юу байгаад, тэгээд зүгээр ч үгүй бүүр 93.4 хувийг нь эзэлсэн ийм айхтар дүн бэ гэдгийг нэг асуучихъя.

Хоёрт энэ 2024 оны төсвийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл ингээд гарсан байгаа тиймээ? Тэгэхээр энэ чинь нөгөө түрүүн гишүүн, Батжаргал гишүүний үгэн дээр гарсан. Энэ асуудлууд чинь ил тод бус ялангуяа энэ ангиллын цаана ямар зардлууд байгаа нь тодорхой бус байгаа учраас дандаа хардлага дагуулаад байна. Ярих юм байхгүй. Ялангуяа сүүлийн үед энэ бие биеийгээ улс төрчид их харддаг боллоо. Ялангуяа төрийн байгууллагад ажилладаг өндөр дээд албан тушаалтнуудыг их хардаж байгаа. Тэгэхээр энэ дээр би энэ Соёл, спорт, аялал жуулчлалын яамны яг энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг эндээс харж байна л даа. 2023 оны гүйцэтгэл дээр үндсэн үйл ажиллагааны зардал гээд энэ чинь нөгөө нийтлэг дотроо дахиад үндсэн үйл ажиллагааны зардал гэрээгээр мэдээлэл гээд ингээд ёстой нэг толгой эргүүлсэн ийм ангилал. Тэгээд 2023 оны гүйцэтгэлээр 702 сая төгрөг байсан байгаа юм. Соёлын яамных. Гэтэл сая 2024 оны гүйцэтгэлээр.

Д.Батбаяр: Баярмаа гишүүн гүйцээж асууя.

Ж.Баярмаа: Тэгэхээр энэ их онцгой анхаарал татсан дүн л дээ. 702 сая төгрөг байснаа нэгхэн жилийн дотор 5.6 тэрбум болоод өөрчлөгдчихсөн буюу нэмэгдчихсэн. Энэ чинь бараг 8 дахин нэмэгдсэн байна шүү дээ. Тэгэхээр жишээлбэл энэ чинь ямар гээчийн үндсэн үйл ажиллагаа вэ? Ямар гээчийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ болохоороо ингээд бараг 8 дахин нэмэгдчихдэг юм бэ гэдэг ийм асуултыг асууя. Гэхдээ яах вэ ерөнхийдөө мэдээж зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Ер нь бол мэдээж энэ чинь төрийн байгууллага. Аль болох л төрийн байгууллагын хийж чадах хийж чадахгүй зүйлүүдийг бусдаар хийлгээ гээд байгаа шүү дээ. Төрийн бус байгууллагууд байна, ААН-үүдээр хийлгээ гээд байгаа энэ зарчим л явж байх шиг байгаа юм.

Тэгэхээр зарчмын хувьд бол дэмжиж байгаа.

Энэ Соёл, спорт, аялал жуулчлалын яамны ТНБД-ын түр орлон гүйцэтгэж байгаа Оюунбилэг дарга ирсэн байгаа юу? Та 4 номерын микрофон дээр суучих. Оюунбилэг дарга өөрөө байхгүй байгаа юм уу? 4 номерын микрофоныг нээе.

Д.Батбаяр: Баярмаа гишүүний асуултад хариулъя.

Ж.Отгонбат: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат байна. Баярмаа гишүүний асуултад хариулъя. 2023 оны төсвийн гүйцэтгэл дээр бол зөвхөн Соёлын яам гэж байсан. Тэгээд 2024 онд бол Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам гээд энэ 4 том салбар нэгтгэгдээд орж ирсэн. Ингээд 4 том тэр 700 сая гэж Баярмаа гишүүн аль тоог нь хэлсэн юм бол. Нэмээд дараа нь танд тодорхой бичгээр хариуг нь өгчихье. Энэ манай салбарын нийт бусдаар гүйцэтгэсэн ажил буюу бүх арга хэмжээний зардлууд бол энэ бусдаар гүйцэтгэсэн эдийн засгийн ангилал дээр байгаад байдаг. Энэ дээр яах вэ нэг 2 юм тодруулж хэлье гэхэд бол 1 дүгээрт энэ зориулалт гээд байгаа юм. Тэгээд бусдаар гүйцэтгэсэн ажил гэсэн эдийн засгийн ангилал байгаа. Энэ 2 нөгөө холиод байх шиг байна. Зориулалтаар нь шалгаад үзэх юм бол манай яг үндсэн үйл ажиллагааны зардлууд түрүүн бас хэн гишүүн хариулж байх шиг байсан.

Спортын гэхэд чинь тэгээд уралдаан тэмцээн олон улсын тэмцээнд оролцогчдын тамирчдын зардал эд нар нь энэ дээр байгаад байна гээд. Яг ийм зориулалтуудаар манай зориулалтууд явдаг. Нийтдээ 2024 оны гүйцэтгэл дээр бол яг одоо 67 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч байгаагаас энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн эдийн засгийн ангилал дээр мэдээж давхар нөгөө манай нийт 486 байгууллага байгаа. Энэ байгууллагуудын даатгалын үйлчилгээ, газрын төлбөр, тээврийн хэрэгслийн оношилгоо, тээврийн хэрэгслийн татвар, үйлчилгээ, мэдээллийн төлбөр, харуул хамгаалалтын зардал гээд бүх энэ байгууллагуудын зардал энэ эдийн засгийн ангиллаар ингээд тавигдчихдаг. Тэгээд эд нар нийлээд явдаг. Тэгээд соёл урлагийн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх зардлууд, биеийн тамир спортын бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх зардлууд, аялал жуулчлал залуучуудын бодлогын арга хэмжээнүүд хэрэгжүүлэх энэ бүх зориулалтуудын зардлууд энэ дээр нэгтгэгдээд тавихлаар таны хэлсэн энэ тоо өссөн харагдаад байгаа.

Д.Батбаяр: Баярмаа гишүүн ингэж асуугаад байна шүү дээ даргаа. 801010 гэсэн кодтой 2023 онд 702 сая 281.5 тэрбум төгрөг байснаа сая төгрөг байснаа 2024 онд 5 тэрбум 597 сая төгрөг болоод огцом нэмэгдсэн байна аа. Энэ ямар учиртай юм бэ? Тэгээд үндсэн үйл ажиллагааны зардал гээд нэмэгдсэн байна. Ямар ямар ажил хийгдсэн юм бэ гээд тэгж асуугаад байна.

Ж.Отгонбат: Энэ нөгөө 4 салбар нэгдэж орж ирсэнтэй холбогдуулаад аялал жуулчлалын салбарын хөтөлбөрүүд орж ирсэн. Тэгээд аялал жуулчлалын салбарын бүх үндсэн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг салбар тухайлбал нөгөө арилжааны банканд олгож байгаа зээлийн татаас юу эд нар бүх эдийн засгийн ангилал дээр энэ тавигдахлаар бусдаар гүйцэтгүүлэх эдийн засгийн ангилал гэдэг ангилал дээр тавигдчихаад байгаа юм.

Д.Батбаяр: Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Би гайхаад байна л даа. Бүүр энэ чинь холион бантан шахам юм биш үү? Уг нь үгүй л байлтай билээ. Тэгээд үндсэн үйл ажиллагааны зардал гэж байгаа юм чинь бүүр маш тодорхой л зардлууд байгаа юм байна шүү дээ уг нь. Энэ чинь үндсэн яамны чиг үүргийнх нь үйл ажиллагаа гэж энэ үгнээс нь уншвал. Гэтэл энэний задаргаа хаана ч байхгүй, 1-д.

Хоёрт энэ яам тэгээд нийлээд 3 яах вэ салбар. Аялал жуулчлал, соёл, спортын яам гэж байсан тиймээ. Тэгээд аялал жуулчлал ороод ирэнгүүт л шууд ингээд 8 дахин нэмэгдчихэж байна уу энэ ямар аймаар их нэмэгдсэн юм бэ гэдгийг л гайхаад байгаа юм л даа. Тэгээд энэний чинь цаана нөгөө хардалтууд явдаг байхгүй юу. Ний нуугүй хэлэхэд. Нөгөө Соёлын яам чинь нөгөө энд тэнд янз бүрийн контент хийчихсэн юм биш үү тэгчихсэн юм биш үү гээд. Надад энийг нөгөө хүмүүс ирүүлээд байгаа юм л даа зориуд. Ийм ингээд ингэж нэмэгддэг юм шүү. Ингэж огцом өссөн шүү. Энэний цаана чинь нөгөө элдэв шалдав янз бүрийн юмыг харлуулахад ашигладаг энэ төлбөр тооцооны чинь.

Д.Батбаяр: Баярмаа гишүүн ахиад нэг минут нэмж асуух эрхтэй байгаа. Микрофоныг нээе.

Ж.Баярмаа: Тэгээд асуулт ер нь тэгээд ойлголоо. Тэгэхдээ ийм тодорхой байх ёстой зүйл буюу үндсэн үйл ажиллагааных нь зардал нь ингээд харагдахгүй

байна гэдэг бол их л сонин л ийм ангиллууд байдаг юм байна. Тэгэхээр энийг бол нэг мөсөн 1 тийшээ маш тодорхой болгохгүй л бол хар бол хэзээ ч салахгүй гэдгийг л одоо сануулж хэлье дээ тиймээ? Тэгээд энийг бол яах вэ иргэдээс ирж байгаа асуултууд энэ ялангуяа соёлын яамтай холбоотой асуулт гомдлууд маш их ирдэг юм л даа.

Тийм учир би зориуд энийг ингээд хараад асууж байгаа юм шүү. Баярлалаа.

Д.Батбаяр: Батболд гишүүн асуулт асууна.

Р.Батболд: Сайн байцгаана уу? Та бүхэн яах вэ энэ бусдаар гүйцэтгүүлэх энэ зардлын ангиллыг ер нь нэмэх боломж байгаа юм уу? Энэ Сангийн яамнаас тэгж асууя. Ер нь бол үндсэн үйл ажиллагааны зардал гээд ингээд тавьчихаад байдаг. Энийг дотор нь яаж задлах юм. Зардлын ангиллыг л ер нь яаж нэмэгдүүлэх юм бэ гэдэг. Тэгээд аудит ч гэсэн энэ дээр юу гэж бодож байна? Ер нь бол энэ үндсэн үйл ажиллагааны зардал гээд дийлэнх нь яваад байгаа юман дээр гол эхний 5-д нь ч гэдэг юм уу нэг тийм тийм зардлууд ороод хамгийн их нь тэр тэр байна гэдэг юм уу одоо тийм нэр төрлөөр нь гаргачих зардал байна уу? Түрүүн Санжаадорж дарга хэлчих шиг болсон. Энэ нөгөө файлаар нь өгчихье гэсэн үү яаж өгье гэсэн бэ? Энэ дээр дарахаар нөгөө цаашаа ингээд задраад харагдаад байдаг байж болох байх гээд ярьсан уу та?

Би нөгөө сонсоод явж байсан болохоор дутуу сонссон байж магадгүй. Тэгэхээр тэр ажлаа хурдан хийчихвэл бид нарт их амар байна. Энэний задаргааг нь хурдан өгөөч гээд. Тийм л асуудал байна.

Д.Батбаяр: 5 номерын микрофон Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Батболд гишүүний асуултад хариулъя аа.

Төсвийн тухай хуулийн 22.2-т нөгөө төсвийг ангилах ангиллыг заасан байгаа. 6 ангиллаар ангилна гэчихсэн ангилалтай. Тэгээд яах вэ юу ерөөсөө таны яг хэлээд байгаа тэр зүйл нь юу вэ гэхлээр нөгөө зөвхөн нэг талаас нь бид нар авч харчихаад бусдаар өсгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд зөвхөн нэг зүйлийг нь хасчихаар цаад деталийг нь харж чадахгүй байгаад байгаа учраас л үл ойлголцол ингээд хардалт үүсээд байна гэдгийг бид маш сайн ойлгосон. Тэгээд сая нөгөө төсөв батлагдахад угаасаа бид нар чиглэл авчихсан. Энэ дээр ер нь анализ хийгээд ер нь цаашдаа яах ёстой юм бэ гэдэг зүйл яриад тэгээд энэ намрын төсөлтэй хамт бид нар шийдлээ барьж орж ирэх юм. тэн дээр хэд хэдэн зүйлүүдийг төлөвлөж байгаа юм. 1 дүгээр асуудал бол үндсэн үйл ажиллагаан дээр үндсэн үйл ажиллагаа гэдэг зориулалт дотор бусдаар үйлчлүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гэдэг эдийн засгийн ангилал байхгүй байлгая аа. Яагаад гэхлээр энэ тодорхойгүй ерөнхийдүү болчихлоо. Тэгэхээр энэ өөрөө хогийн сав болох магадлалтай байна гэдэг нэг агуулга.

Тэгэхээр бүгд юу гэдэг юм мэдээлэл сурталчилгаа ч гэдэг юм уу юу гэдэг юм уралдаан тэмцээн гэдэг юм уу, яг ийм зориулалт нь гарч ирчхээд тэр тодорхой зориулалтынх нь дотроо л зөвхөн энэ эдийн засгийн ангиллаа тавья гэдэг нэг дэх агуулга.

Хоёр дахь агуулга бол энэ дээр бол бид нар бид нар цахимжуулалтыг бол хийгээд эхэлчихсэн байгаа. Түрүүний лог гэж хэлээд байгаа нь бол гүйлгээний тоогоо яриад байгаа юм. Цаад талд нь бол нөгөө нэг анхан шатын баримтаа нөгөө хавсаргачихсан байгаа учраас тэрийг нь шууд цахимаар татаж гарч ирээд шатахуун аваад байна уу эсвэл өөр юм аваад байна уу гэдэг нь харагдчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр шатахуун авч байна гэдэг чинь зүгээр үндсэн үйл ажиллагааны гэдэг зориулалт дотор шатахуун гэдэг эдийн засгийн ангилал дээрээ л тавих ёстой байхгүй юу тиймээ. Тэгэхээр тэнд нь шатахуунаа ингээд бага тавьчихаад тэндээсээ гаргаад байвал энэ зориулалт бус байна л гэдэг зүйл хараг даад байгаа юм.

Тэгэхээр тэр 100 мянга гаруй жишээ нь нэг байгууллага дээр гарч байгаа гүйлгээг бид нар цаашдаа яаж хянах вэ гэхлээр одоо манай яаман дээр байгаа хориод хүнтэй Төрийн сангийн газар бол бүгдээрээ өдөр шөнөгүй хараад ч амжихгүй. Тийм учраас энийг цахимжуулж хийнэ гэж байгаа юм. Тэгэхээр ирэх жилийн 1 сарын 1-ээс ерөөсөө яг ийм ийм ийм зориулалтын зардал л гарна гэдэг нэг дэх агуулга.

Бас 2 дахь агуулга орж ирж байна. Тэгэхээр 1 талаасаа бид нар төлөлт талаасаа хасна. Энэ бол энэ ангиллаас гарах зориулалтын биш байна гэдэг зүйл. Тэгэхээр намрын төсөв дээр бол энэ жил бол жишээ нь 1.7 их наяд төгрөг батлагдсан бол бид нарын зүгээр анхан шатын үр дүн бол хараахан би эцсийн байдлаар гараагүй байна. Тэгэхдээ бол юу гэдэг юм лав 50 хувиар энэ доошоо дүн нь цэвэрлэгдэж бууж орж ирэх юм байна гэдэг агуулга харагдаж байна.

Хоёр дахь нь энэ цахимжуулалтаа бид нар оруулчихна. Тэгээд ингэчихнэ. 3 дахь бид нарын хийх ёстой ёстой ажил юу вэ гэхээр мэдээллийг нээлттэй ил тод тавих асуудал байгаад байгаа. Тэгэхдээ тэрэн дээр анализ хийж болохуйцаар. Яагаад гэхээр нөгөө зөвхөн нэг талыг нь харчихлаар жишээ нь Сүхбаатар аймгийн төсөв гээд л харчих юм бол их дүн гарч ирчхээд энэ яахаараа ингэдэг юм бэ гэдэг асуудал гарч ирнэ. Тэгтэл цаашаагаа задлах юм бол эрүүл мэндийн салбартаа хэдэн төгрөг гэдгийг нь харж болно. Эрүүл мэнд дотроо нэгдсэн эмнэлэг нь хэд гэдгийг харж болно. Анхан шатын буюу сумын эмнэлгүүд нь хэд гэдгийг харж болно.

Ингээд харахаар энэ өөрөө илүү ойлгомжтой болж байгаатай яг ижилхэн хэн саяын эдийн засгийн ангиллын бид нар илүү тийм нээлттэйгээр бүх талаас нь оруулах байдлаар нээлттэй мэдээллийг ил тод тавья гэж байгаа юм. Энэ дээр 2 янзын мэдээлэл тавих асуудал ярьж байгаа юм.

Нэгд бол Төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралт дээр одоо бид нар энэ эдийн засгийн ангиллаа тавьчихаад доод тал нь төсвийн ерөнхийлөн захирагчаа тавиад доор нь болохлоороо зориулалтуудаа тавиад ингээд аль сайд дээр хэдэн төгрөг яг ямар зориулалтаар энэ эдийн засгийн ангиллаар төлөвлөгдөөд орж ирэв гэдэг нь гишүүдэд нээлттэй харах мэдээлэл өөрөөр хэлбэл тооцооллын хавсралт дээр батлагдах.

Хоёр дахь нь бол энийгээ анализ хийх зорилгоор анализ хийх форматик маань үндсэндээ эксель дээр гэсэн үг. Эксел дээр энэ файлыг нээлттэй бас хавсаргаж Их Хуралд хүргүүлэх ийм 2 ажлыг.

Д.Батбаяр: Аудитын байгууллагын 3 номерын микрофон. Батболд гишүүний асуултад хариулъя аа.

Ц.Наранчимэг: Үндэсний аудитын газар Наранчимэг. Батболд гишүүний асуултад хариулъя.

Бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал дотор төлөвлөж байгаа яг одоогийн мөрдөж байгаа хэд хэдэн зардлууд байгаа. Тэгэхдээ энэ бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас зарцуулахдаа одоо төсвийн хуваарьт өөрчлөлт орж үндсэн төлөвлөж болох зардлуудыг зарцуулаад байгаа дээр аудитын байгууллага бол бас яг бодитой төлөвлөж энэ бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалд яг ямар зардлыг тусгах юм тэрийг нь яг зориулалтаар нь ямар зүйлд зарцуулах юм гэдгээ тодорхой болгох шаардлага байна гэдгийг хэлж байгаа.

Сангийн яам бол бас тодорхой ажлуудыг хийж байгаа. Бид нар энэ хийсэн ажлуудын үр дүнг 2026 оны төсвийн төслийг өргөн барихад бол энэ асуудал дээр анхаарч аудитынхаа нэг горим сорилоор хэрэгжүүлнэ. Мөн саяын 2024 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн аудитыг хийхдээ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг бид нар.

Д.Батбаяр: 3 номерын микрофон гүйцээж хариулна аа.

Ц.Наранчимэг: Аудитаар энэ бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг бас энэ дээр тодорхой эрсдэлүүд байх ийм магадлалтай гэж үзэж горим сорил хэрэгжүүлсэн. Эндээс энийг маань энэ зардлуудыг тодорхой яг энэ зарцуулагдах зүйлд нь төлөвлөхгүй бол эдгээр зардлууд нь эдийн засгийн ангиллаар хянагдах боломжтой. Төсөв дутагдсан тохиолдолд бас бусдаар гүйцэтгэж ажил үйлчилгээнээсээ зориулалт бус зардлууд гаргаад байгаа учраас энийг төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бол энэ ангилал бууруулаад байна гэдэг ийм асуудлыг тайландаа оруулж өгсөн.

Д.Батбаяр: Шижир гишүүн асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Би энэ Дэд хорооны гишүүн биш л дээ. Гэхдээ сонирхоод ороод ирсэн юм. Хэдэн юм асуух гээд жишээ нь энэ 2022 оны гүйцэтгэл, 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл гээд. 2023, 2024 он бол өөрөө сонгуулийн жил байсан. Нэг нь сонгуулийн жил угтсан нөгөөдөх нь тухайн оны сонгуулийн жил байсан. Тэгээд энэ мэдээлэл сурталчилгааны зардал дээр СЕХ-ны зардал жишээ нь мэдээлэл сурталчилгааны зардал нь 68 сая төгрөг байгаа юм СЕХ-ных шүү. Гэтэл Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны гүйцэтгэл нь 2 тэрбум, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл нь 2 тэрбум, Монгол Улсын Ерөнхий сайдынх 9 тэрбум, 2024 оных 15 тэрбум, ЗГХЭГ-ынх 2.4 тэрбум, Сангийн сайдынх 2023 оны гүйцэтгэл нь 373 тэрбум, 2024 оных нь 231 сая уучлаарай. Батлан хамгаалахын сайдынх 2022 оны гүйцэтгэл нь 278 сая гэх мэт. Эрүүл мэндийн сайдынх 2022 оны гүйцэтгэл нь 399 сая, ҮХЦ-ийн даргыг ойлгоё гэж бодъё. Монгол Улсын Шадар сайд 2023 оны гүйцэтгэл нь 111 сая, 2024 оных нь 420 сая.

Сонгуулийн хорооны даргын гүйцэтгэлийг бид нар ойлгож байна аа. Сонгуульт ажил. АТГ-ыг ойлгож байна аа. Урьдчилан сэргийлэх ажил гээд зөв өө. Тэгэнгүүт л нь Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны гүйцэтгэл нь 336 сая, Боловсролын сайдын 2022 оны гүйцэтгэл нь 685 сая, Зам тээврийн сайдын 2022

оны гүйцэтгэл нь 306 сая, хуучнаар Уул уурхайн яамны 2022 оны гүйцэтгэл нь 331 сая, 2024 оных нь 154 сая, ХАА-н сайдын 2022 оных нь 345 сая. Эрчим хүчний сайдынх 2022 оных нь 240 сая, Гэр бүл, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэл сурталчилгааны зардал нь 2022 оны гүйцэтгэл нь 337 сая, 2023 оны гүйцэтгэл нь 272 сая.

Ингээд мэдээлэл сурталчилгаа руу бараг зөвхөн энэ хэдхэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг харахад бараг 10 тэрбум руу дөхчхөж байна л даа. Тэгээд яагаад 2022 он, 2023 оныхыг яриад байна вэ гэхээр энэ нь ерөөсөө сонгуулийн өмнөх жил болон сонгуулийн жил байхгүй юу. Тэгэхэд та нар бод доо СЕХ нь өөрөө 2024 оны гүйцэтгэлд 28 сая төгрөг байна шүү дээ. Тэгээд яамдуудын төсвийн ерөнхийлөн захирагчдын энэ мэдээлэл сурталчилгааны зардал гэдэг чинь юунд зарцуулагддаг юм бэ? Сүүлд манай нэг Их Хурлын гишүүн чуулган дээр яг энэ асуудлыг ярьж байсан. Тэгээд арай үгүй байлгүй дээ гэсэн одоо энэ чинь аягүй өндөр тоонууд байна шүү дээ. Сангийн сайдыг гэхэд л зүгээр 2022 оных нь 373 сая, 2023 оны гүйцэтгэлд 231 сая. Зөвхөн мэдээлэл сурталчилгааны зардалд.

Д.Батбаяр: Сангийн яамнаас 5 номерын микрофоныг нээе.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 сарын 22-нд батлагдсан. Уг хуулиар бол мэдээлэл сурталчилгааны зардлыг бол гаргах хууль тогтоомжийг сурталчлахтай холбоотойгоор тухайн байгууллагын гаргасан тухайн байгууллагатай холбоотой хууль тогтоомжийг сурталчлахтай холбоотойгоор зарцуулна гэсэн тийм хууль байгаа. Зүгээр юу гэдэг юм энэ хэтэрхий өндөр байна, бага байна гэдэг юм уу тийм агуулгаар асуухаар илүү улс төрийн хүмүүсээс л асуухгүй л дээ. Та нарын хувьд би яг мэргэжлийн талаас нь.

Д.Батбаяр: Яг 2024 онд нэмэгдээд огцом нэмэгдсэн байна гэдэг тийм яг тэр байдлаас нь асуугаад байна. Яагаад ингэж хэвийн явж байгаад сонгууль дөхөөд ирэхтэй зэрэгцээд нэмэгдсэн юм бэ гэдэг байдлаар асууж байна.

М.Санжаадорж: Одоо тэрэн дээр би яг ийм гэж хэлэхэд хүнд хэрэгцээ шаардлагаар нь угаасаа ингэж л орж ирж байгаа. Тийм байдлаар л төлөөлөөд л тэгээд гүйцэтгэл нь гарч байгаа л гэж.

Аудитын байгууллагаас хариулъя. Энэ эдгээр зардлууд дээр нь шинжилгээ хийсэн үү дүн шинжилгээ хийсэн үү гэж асуусан.

Ц.Наранчимэг: Үндэсний аудитын газар Наранчимэг. Мэдээлэл сурталчилгааны зардлыг аудитын байгууллага сая аудит хийхэд энийг яг бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал бол мэдээлэл сурталчилгааны зардлыг төлөвлөнө өө гэсэн ангилал байж байгаа. Гэхдээ энэ бараа ажил үйлчилгээний зардал бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал 2 дээр хоёулан дээр нь төлөвлөгдөөд байгаа. Тийм учраас энийгээ яг аль зардалд энэ мэдээлэл сурталчилгааны зардал төлөвлөгдөх юм бэ гэдэг дээр анхаарах шаардлагатай байгаа.

Мөн сая Санжаадорж дарга хэллээ. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхлээд мэдээлэл сурталчилгаатай холбоотой зардлуудыг хориглосон заалт дээр үндсэн үйл ажиллагаатай холбоотой Улсын Их Хурал Засгийн газрын хууль

тогтоомжийг сурталчлах зардалд бол мэдээлэл технологи, энэ мэдээлэл сурталчилгааны зардлыг гаргаж болно гэж энд заасны дагуу бид нар асуудлууд.

Д.Батбаяр: Шижир гишүүн тодруулж асууна аа.

Ө.Шижир: Та нарт зүгээр нэг юмтай л харьцуулах гэсэн юм. СЕХ-ны даргын 2023 оны гүйцэтгэл, 2024 оных нийлээд 80, 90 орчим сая төгрөг байгаа. СЕХ шүү дээ. Сонгуулийн ерөнхий яагаад гэвэл сонгуулийг сурталчлах өглөө хэдэн цагаас эхлэх, хэдэн цагт тарах, яаж санал өгөх ийм сурталчилгаа явдаг. АТГ яадаг вэ гэхээр соён гэгээрүүлэх ажил хийдэг. Үнэ 55 сая төгрөг, 2024 оных нь, 2023 оных 60 сая 40 ингээд 110 сая төгрөг энэ хоёрынх нийлээд ингээд 180 сая төгрөг. Хамгийн чухал ач холбогдолтой байгууллагууд нь. Гэтэл хууль тогтоох байгууллага буюу Улсын Их Хурлын дарга дээр Улсын Их Хурлын даргын бүтэц дээр 2024 онд 2 тэрбум 184 сая. Надаа дахиад нэг минут нэмээд өгчих дарга.

2023 буюу сонгуулийн өмнөх жилийнх дээр 2 тэрбум, Ерөнхий сайд дээр 15 тэрбум, Хэрэг эрхлэх газар дээр 2 тэрбум. Сангийн сайд дээр 370 хэдэн сая. Эд нар чинь ингээд бүгдээрээ л нэг хуулийг бүх талаас нь тайлбарлаад байдаг юм уу?

Д.Батбаяр: Шижир гишүүнд дахиад нэг минут сунгаж өгье. Батлагдсан хуулийг өөр өөрсдийнхөөрөө тайлбарлаж сурталчлаад байдаг юм уу? Тэгээд сонгуулийн өмнөх жил огцом өсдөг нь ямар учиртай юм? Одоо энэ чинь Улсын Их Хурлаас баталж байгаа хуулийг чинь бодвол Улсын Их Хурлын Тамгын газраас мэдээлэл сурталчилгаа гээд явж байгаа. Энэ Их Хурлын Тамгын газар дээр байгаа Улсын Их Хурлын дарга дээр байгаа бүтэц 2 тэрбум. Тэгээд сайдууд дээр ингээд давхар нэмэгдээд байдаг нь ямар учиртай юм? Нэг хуулийг яадаг юм нийгмийн даатгалын хууль гээд батлагдахаар Сангийн яамнаас сурталчлаад нийгмийн даатгалын газраас нэг сурталчлаад, Их Хурлаас нэг сурталчлаад Ерөнхий сайдаас ингээд бүх төрийн байгууллагууд адилхан сурталчилгаа хийдэг юм уу. Тэгээд яагаад сонгуулийн өмнөх жил өсөөд байгаа юм. Яагаад 2, 3 дахин өсөөд байгаа юм. Би энийг л асуугаад байгаа юм. Хэмнэлтийн хууль гээд та нар нэг гоё тайлбар нэг онц сурдаг хүүхдүүд шиг тайлбарлаад байх юм. Хэмнэлтийн хууль чинь хэрэгжихгүй байгаа шүү дээ. Төсөв тодотгох болохоор л хэрэгждэг юм. Энийг надаа яг та тэр аль ангилалд нь орсныг эргээд харъя. Та тэрийг нэг тодорхой хэлээд өгөөч тэгэх үү?

Д.Батбаяр: Үндэсний аудитын газар хариулах уу? Эсвэл дараа нь бэлдэж байгаад хүргүүлэх үү? 3 номерын микрофоныг нээчихье.

Ц.Наранчимэг: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан дээр улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагааны зардлын зарим арга хэмжээнүүдийн зардал, бусад эдийн засгийн ангиллаар хянагдах боломжтой зардлуудад төсөвлөсөн байна гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байгаа. Энэ дээр мэдээлэл сурталчилгааны зардал дээр 3 тэрбум төгрөг байгаа. Эрдэм шинжилгээ судалгааны зардал дээр 27.2 тэрбум, сургалт семинар дээр 6.4 тэрбум олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулахад 4.5 тэрбум гэх мэтчилэн эдгээр зардлуудыг төлөвлөх боломжтой зардлуудад төлөвлөсөн байна аа.

Энэ дээр аудитын байгууллагаас энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ болон бусад зардлын ангиллаар зарцуулж байгаа төсвийг гарах үр дүн үр ашгийг нь тайлагнаж баймаар байна аа. Ямар үр дүнтэй ажил зохион байгуулсан юм, ямар үр ашиг.

Д.Батбаяр: Одоо би асуулт асуучихъя аа. Би тэгээд нэлээн асуултууд давхцаж байгаа учраас маш товч бөгөөд тодорхой асуухыг бодъё оо. Сангийн яамнаас асуулт байна. Санжаадорж дарга аа. Энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал жилээс жилд өсөж байна гэдгийг сая бид нар бүгдээрээ харлаа. Тэгээд 2023-аас 2024 онд 704 тэрбум байсан зардал маань 957 тэрбум болоод өсчихсөн байна.

Тэгээд төсвийг үр ашигтай хэмнэлттэй энэ төлөвлөж зарцуулах зарчим энэ дээр ер нь ямархуу хэрэгжиж байна гэсэн асуулт байна. Тоон дээр нь биш шүү. Энэ баримталж байгаа зарчим дээр нь би сууж байгаа юм. Тэгээд зарцуулалтын, зориулалтын дагуу гэдгийг яаж хянаж болж байгаа юу? Сая Үндэсний аудитын газраас хэлж байна лээ. Хянаж болдог зардал хянаж болдоггүй зардал гэж 2 байгаа юм байна. Тэгэхээр энэ зарцуулалтыг яг зориулалтынх нь дагуу гэж хянаж болж байгаа юу? Гүйцэтгэлийг хийхэд.

Хоёрдугаар асуулт нь энэ төрийн худалдан авах үйл ажиллагааны хуулийг яг мөрддөг үү. Гүйцэтгэгчийг нь хэрхэн сонгодог вэ? Нээлттэй ил тод явагддаг уу гэдэг дээр та байр сууриа илэрхийлчих.

Гуравдугаарт нь энэ үндсэн үйл ажиллагааны зардал зэргийг нөгөө дахин ингээд дахиад задалж харах боломж байна уу? Сая бараг гишүүн болгон асуулаа шүү дээ. Яг бусдаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал гэгчхэнгүүтээ ахиад тэр дунд нь орж ирээд үндсэн үйл ажиллагаа гээд дахиад ороод ирчихсэн яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр зөвхөн энэ үндсэн үйл ажиллагааны зардал ахиад эрдэм шинжилгээний зардал гээд ингээд том том том үнийн дүнтэй зардлууд байгаа. Энийг ахиад нягтлах боломжтой юу? Зардлыг нь ахиад задлах боломж байгаа юу? Тэгээд эд энэ зардлууд чинь ингээд бүгдээрээ ингээд Шилэн дансанд бүртгэгдээд явж байх ёстой байх тиймээ. Тэгээд эд нар ингээд ороод явж байгаа юу гэсэн ийм 3 асуултыг Сангийн яамнаас асууна.

Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас асуух асуулт байна. Зөвхөн энэ төсөв нь үйл ажиллагаандаа түрүүн Баярмаа гишүүний хэлдэг 8 дахин өсчихсөн байна гэж ярьсан тиймээ. Тэгээд энэ дээр энэ олон улс дахь Сурталчилгаа мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагааны хэрэгжилт гээд 2024 онд нь 6 тэрбум болсон байгаад байгаа юм. Энэ чинь нөгөө нэг Солонгосоос нэг баахан хүмүүс орж ирээд л бас ахиад нэг Америкаас хүмүүс хүрч ирээд байсан ирээд байсан энэтэй холбоотой зардал. Тэгээд энэ дээр чинь ямархуу байдлаар сонгон шалгаруулж энэ хүмүүсийг авчирсан юм бэ? Яг энэ төрийн худалдан авах үйл ажиллагааны хуулийг энэ дээр бол мөрдөөгүй байгаа. Шууд захиалаад аваад ирсэн байх уу? Энэ ямар байдлаар явсан бэ? Тэгээд энэ хүмүүсийг авчирч энд Монгол Улсыг сурталчлуулсан энэ үйл ажиллагаа маань өөрөө ямар үр дүнтэй байсан бэ? Энэ дээр үр дүнгийн шинжилгээ хийсэн үү? Боловсролын яам байгаа тиймээ. Боловсролын яам нэг номерын сандал дээр ирээд суучхаарай.

Тэгээд энэ Боловсролын яамнаас түрүүн бас асууж байсан. Энэ дотуур байрны үйл ажиллагааны зардал гээд 16 тэрбум маань 85 тэрбум болчихсон байгаа. Сангийн яамны 5 номерын микрофоныг нээе.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Батбаяр гишүүний асуултад хариулъя. Төсвийн үр ашгийн хувьд бол илүү Сангийн яам гэдэг талаасаа илүү

хөндлөнгийн аудитын байгууллагаас бол илүү тодруулах нь зөв байх. Бид нарын зорьж байгаа зүйл бол юу вэ гэхээр одоо бол урсгал зардал хөрөнгө оруулалтын зардлын харьцаа 75, 25 орчим байгаа. Бид бол урсгал зардлыг аль болох бага хэмжээнд байх, нөгөө талдаа хөрөнгийн зардлыг буюу бүтээн байгуулалтын зардлыг илүү нэмэгдүүлэх чиглэлд бол ажиллаж байна. Одоогийн төсвийн тодотгол болон цаашид ирэх жилийн төсөв бол тэр чиглэл рүүгээ явна гэж бол бид нар харж байгаа.

Ер нь бол төсвийг бол бид нар нэгэнт ингээд урсгал зардлаа нэмж чадахгүй, зардлаа бас ингээд уул уурхайгаас дэндүү хамааралтай орны хувьд бол огцом нэмж чадахгүй ийм тохиолдолд бол бид нар энэ төсөвтөө хүргэж л багтааж л төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлыг ярих ёстой. Өөрөөр хэлбэл бүтээмж гэдэг асуудал ярих ёстой энэ дээр. Тэгэхээр бүтээмж нь бол энгийн нэг хүн төрийн албан хаагч аваад ажиллуулахаас илүү яаж бид нар тэрийг илүү сайжруулж болох вэ гэдэг асуудал нь бол хувийн хэвшлээр буюу явуулах эсвэл төрийн зарим үйлчилгээг өөрт нь бол төрийн албан хаагч байсан ч гэсэн хийсэн ажлаар бид нар ингээд санхүүжилтийг нь олгох асуудал чухал байгаа. Тэгэхлээр энэ чиглэл рүү явж байгаа. Энэ эдийн засгийн ангилал бол ер нь бол тэр чиглэл рүү явж байгаа асуудал. Хянаж болж байгаа юу гэж асуулт асууж байна. Хянаж болно оо. Хянах асуудлыг бол бид нар энэ жилээс цахимжуулаад хийж байгаа. Түрүүн би бас дурдсан танд. Энэ олон гүйлгээнүүдийг бол хувь хүний байдлаар бол бид нар хийж чадахгүй байна. Тийм учраас бол энийг бол илүү юу гэдэг юм цахим болгож байгаа. Хянахдаа бол та түрүүн шилэн данстай уяж асуусан. Шилэн дансны тухай хууль дээр бол 5 сая төгрөгөөс дээшээ ажил үйлчилгээг бол шууд бид нарт тавих ёстой байгаа. Гэхдээ бол энийг бол бид нар өмнө нь бол тухайн байгаа төсөвт байгууллагын нярав нягтлан материалаа оруулаад оруулаагүй тохиолдолд ингээд хариуцлагын асуудал ярьдаг ч юм уу одоо оруулсан, оруулаагүй гэдэг ийм зүйл ярьдаг байсан бол манай дээрээс бол автомат болгоод гүйлгээгээ хийхдээ заавал анхан шатын баримтыг нь хавсаргаад тэгээд гүйлгээ дарагдлаа. Анхан шатын баримт нь автоматаар систем рүү татагддаг болгож бол өөрчилчихсөн байгаа.

Тэгэхээр бол тэр 5 саяас дээш хувь нь бол ороод явж байгаа гэсэн үг болж байна. Худалдан авалтын асуудлыг асуулаа.

Худалдан авалт бол өөрөө бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиар бол өөрөө босго үнэ тавьсан байгаа. Тэр босготоо бол тааруулаад ямар ч тохиолдолд нээлттэйгээр хамгийн бага байлаа гэхэд харьцуулалтын аргаар тэгээд тэр босгоосоо давсан тохиолдолд бол тендер зарлах байдлаар бол ингээд явах ёстой гэдэг асуудал ярьж байна. Ярьж байгаа. Сүүлийнх нь бол үндсэн үйл ажиллагааны зардлыг бол та асууж байна. Үндсэн үйл ажиллагаан дотор бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж орчихоор бол хэт ерөнхий байна гэдэг ийм асуудал бол бид нарын нөгөө намар нөгөө Их Хурлаас өгсөн тэр нөгөө үүргийн дагуу бид нар шинжилгээ хийхэд эхний байдлаар гараад ирчхэж байгаа. Тэрэн дээр Сангийн яамны хувьд бид санал нэг байгаа.

Иймээс бол ирэх жилийн төсөв дээр үндсэн үйл ажиллагаан дээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж гэдэг энэ эдийн засгийн ангиллыг бол нийлүүлж тавихгүй гэдэг ийм бодлого бол барьж байгаа. Тэгэхээр ирэх жилийн төсөв дээр бол зөвхөн үндсэн үйл ажиллагаанаас бусад гэхдээ бол байх ёстой зориулалтыг бол бид бол судалгааны эхний ээлжид бол 20 орчим ерөнхий тийм

байж болох тэгэхдээ хэт ерөнхий биш саяынх шиг дахиад үндсэн үйл ажиллагаа болчихгүйн тулд тодорхой заасан тийм 20 орчим зориулалт байх боломжтой гэдэг дүгнэлт гарч байгаа. Тэрийг илүү тодорхой болчихоор бид нар тэр тооцооллоо ирэх жилийн төсөв дээр төсвийн төсөлдөө тусгаад тэгээд оруулж ирнэ ээ. Баярлалаа.

Д.Батбаяр: 4 номер.

Ж.Отгонбат: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат. Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газар 103 дугаар тогтоолоор Монгол Улсыг олон улсад сурталчлах мэдээллийн үндэсний хороог байгуулж Соёлын сайдаар ахлуулсан. Энэ хүрээндээ бол Соёл, спорт, аялал жуулчлалын яам олон улсад Монгол Улсыг таниулах Монгол Улсыг олон улсад нээлттэй ийм орон болох ийм зорилтыг тавьж ажилласан. Энэ хүрээндээ Засгийн газрын тогтоол гараад тогтоолоор бол олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах ийм Засгийн газар тогтоолоор ирүүлсэн. Энэ хүрээндээ бол CNN, Бостон консалтинг, Эдлмен зэрэг ийм олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулаад энэ олон улсын хэвлэл мэдээллийн байгууллага олон улсын мэдээлэл.

Д.Батбаяр: 4 номерын микрофон гүйцээж хариулъя.

Ж.Отгонбат: Монгол Улсыг сурталчлах үйл ажиллагаа явуулсан, та түрүүн нөгөө гаднаас ирж байгаа инфлүнсерүүдийг урьж авчирсан гэж асуултаа асуусан тиймээ? Энэ асуултын хүрээнд бол Монгол Улсаас ... гэрээ байгуулаад ирсэн байна. Энэ хүрээндээ үр дүн яаж гарсан юм бэ гэж та түрүүн асуусан. Энэ асуултад хариулахыг хичээе.

Монгол Улс 2024 онд дэлхий даяар 430 сая гаруй хандалттай явж олон улсын сэтгүүлээс 2020 онд зочлох хамгийн шилдэг орон Сингапурын Маркетинг сортын холбооноос зохион байгуулдаг Кретив Сөрк Левардс гэдэг Go Mongolia үндэсний брэнд 555 брэндийн дундаас үзүүлэн олон улсад бол мөнгөн цомыг авсан. Энэ хүрээндээ бол go Mongolia брэнд олон улсад Монголын талаарх эерэг сэтгэгдэл төрүүлж эерэг сэтгэгдэл олон улсад төрүүлэх 80 хувьтай, аялах шийдвэр гаргалт.

Д.Батбаяр: 4 номерын микрофоныг нээе. Гүйцээж хариулъя.

Ж.Отгонбат: Хурдтай өсөж буй эдийн засаг хэмээх ойлголттой 31 хувь нөгөө бизнес хөрөнгө оруулалтын сонирхол 40 хувиар тус тус өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад ийм өссөн ийм үр дүн гарсан байна. Олон улсад Монголыг ингэж эергээр хүлээн зөвшөөрч таньж мэдсэн байна аа. Мөн үүний үр дүнд Монгол Улсад зорчих жуулчдын тоо 808 мянгад хүрч экспортын орлого 1.6 тэрбум ам доллар хүрч зөөлөн хүчний олон улсын индексээр Монгол Улс 14 байраар урагшилсан ийм үр дүн амжилтыг бол үзүүлсэн ийм үр дүнтэй байна аа.

Д.Батбаяр: 1 номерын микрофон, Боловсролын яам.

Э.Адъяасүрэн: Боловсролын яамны санхүүгийн хэлтсийн дарга Адъяасүрэн гишүүний асуултад хариулъя.

Боловсролын сайдын багцад батлагдсан дотуур байрны үйлчилгээ зориулалт дээр батлагдсан 85 тэрбум төгрөг бол дотуур байранд амьдарч буй хүүхдүүдэд олгох хувьсах зардал. Дотуур байрны хэвийн үйл ажиллагааг хангах зориулалтаар батлагдсан. Нэмэгдсэн шалтгаан нь хувьсах зардлын хэмжээ болон түүний бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор нэмэгдсэн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт нь бол захиргаа аж ахуйн албан хаагчдын цалин хөлс энэ юун дээр орж ирсэн байгаа, хувьсах зардлын хэмжээн дотор орж ирсэн байгаа.

Д.Батбаяр: Би тодруулж асууна аа. Боловсролын яамнаас. Танай яам дангаараа хамгийн их өсөлттэй байгаад байгаа. Бусдаар гүйцэтгүүлсэн үйл ажиллагаан дээрээ. Тэр дундаа энэ Боловсролын ерөнхий газар. 31 тэрбум 2023 онд зарцуулж байсан бол 2024 онд нэг 103 тэрбум. Нэгхэн жилийн дотор 70 тэрбум төгрөг нэмээд зарцуулчихсан байгаа. Тэгээд түрүүн хэлж байна. Дотуур байрны үйлчилгээн дээр энэ 2023 онд 16 тэрбум төгрөг байсан зардал жилийн дотор 85 тэрбумын болоод 70 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа байхгүй юу. Тэгээд ийм их оюутны байр бий болсон юм уу? Эсвэл оюутны байранд байгаа оюутнуудад ингэж их мөнгө зарцуулсан болж таарч байна уу? Энийг та нэг тодруулаад хэлчээрэй.

Сангийн яамнаас бас нэг асуултаа тодруулмаар байна. Та түрүүн хэллээ шүү дээ. Орон тоогоо багасгаад бусдаар буюу төрийн бус байгууллагуудаар зарим ажлуудыг хийлгэж байгаа гэсэн. Энэний үр дүнг хэмжсэн байгаа юу? Ер нь хэдий тооны цомхотгоод, ажлын байрыг цомхотгоод тэгээд гарсан үр дүн нь ямар байгаа вэ? Энэ дээр дүн шинжилгээ хийсэн юм байгаа юу?

Хоёрдугаарт нь болохоор 5 саяас доош үнийн дүнтэй гүйлгээнүүдийн баримтуудыг гаргаад ирүүлэх боломжтой юу? Яг энэ 5 саяас доошоо жижгээр гарсан 4-өөс 5 сая төгрөгийн хоорондох хэмжээтэй гүйлгээнүүд ер нь хэдэн гүйлгээ байгаа вэ? Энийг та шууд хэлэх боломж байгаа юу?

Санжаадорж дарга эхлээд хариулчихъя. 5 номерын микрофон.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Батбаяр гишүүний асуултад хариулъя. Гүйлгээний тоо бол маш их. Бид бол аль болох Үндэсний аудитын газраас бол ер нь 5 сая гэлтгүй 5 саяас дээш гэлтгүй доошоо ч гэсэн гүйлгээнүүдийг ингээд оруулах талд нь анхаараач гэдэг зүйлүүд хүсэлтүүд ирж байгаа. Бид нар бол тэрэн дээр ажиллаж байгаа. Одоо бол бүх юу бол цахим болчихсон байгаа. Яг төсвийн шууд захирагч нар болон нягтлангууд энийг маш сайн мэдэж байгаа. Ямар нэгэн байдлаар бол анхан шатын баримт нь хийхгүйгээр гүйлгээ хийх бол боломжгүй. Бүр файл нь ингээд сэйвлэгдэхгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр тэр бол бараг хэдэн саяар яригдах гүйлгээ байгаа учраас би танд тэрийг шууд хэвлээд өгнө ч гэдэг юм уу тэгж хэлж чадахгүй байна. Программын асуудлыг бол би илүү нөгөө талд нь тэр цахим асуудлаа хариуцсан төрийн сангийнхантайгаа ярих нь зүйтэй байх гэж бодож байна.

Д.Батбаяр: 5 номерын микрофон үргэлжлүүлж хариулъя аа. Гүйцээж хариулъя.

М.Санжаадорж: Орон тооны асуудал дээр бол ийм байгаад байгаа юм. 10 орон тоог жишээ нь магадгүй ингээд цэвэрлэгээ үйлчилгээний 10 орон тоог ч гэдэг юм уу бид нар хасаад яг тэр хэмжээний зардлаар бол нөгөө талд нь яг ижил

үйлчилгээ авна гээд бол тавих юм бол энэ өөрөө бол бас одоо бол юу гэдэг юм айхтар хэмнэлт гээд гараад байх зүйл байхгүй. Гол асуудал нь бүтээмж дээр яригдана. Жишээ нь хувийн хэвшил хэрвээ ороод ирчихсэн тохиолдолд төрийн алба шиг ингээд байнга 1 дүгээрт бол юу гэдэг юм. Яг механикаар ч гэдэг юм уу зүгээр бүтээн хөдөлмөрийг арай өөрөөр хийж байгаа, илүү цахимжуулалт, илүү техникийн хүчээр бол хэрэгжүүлж байгаа нэг асуудал байгаа. Нөгөө талдаа хувийн хэвшил бизнес эрхэлж байгаа тохиолдолд үгүй ядаж бол татвараа төлнө. ААНОАТ тийм ээ.

Ингээд явсан тохиолдолд энэ нь өөрөө бүтээмжийн хувьд бол илүү байна гэж харж байгаа юм. Мөн 10 хүний хийх байсан ажлаар магадгүй бид нар 15 хүний хийх ажлыг бол хийлгүүлэх.

Д.Батбаяр: Нэг номерын микрофон Боловсролын яам.

Ж.Отгонбат: Гишүүний асуултад хариулъя. 2022 оноос боловсролын салбарын хувьд нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоож гүйцэтгэлийн санхүүжилтийн хэлбэр рүү шилжсэн. Тэгээд үүнтэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургалтын үйл ажиллагаатай холбоотой нэг хүүхдэд ноогдох хувьсах зардал, дотуур байрны үйлчилгээтэй холбоотой нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын хэмжээг ингэж Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор тогтоож өгсөн. 2024 оны төсвийн жилийн хувьд ЕБС-ийн дотуур байранд 35817 хүүхэд суралцаж байгаа. 526 дотуур байр. Үүнд бол 3619 албан хаагч ажиллаж байгаа. Тэгээд яг энэ 85.1 тэрбум төгрөг нь бол зөвхөн яг энэ дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн дотуур байрны хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой. Тэнд ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлс.

Д.Батбаяр: Нэг номерын микрофоныг нээе, гүйцээж хариулъя.

Ж.Отгонбат: Цалин хөлстэй холбоотой зардал байгаа. Яг дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын хэмжээг Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор 2 сая 384 мянга болгож тогтоосон. Өмнө нь яг энэ гэнэтийн яагаад ийм өсөлт байгаа вэ гэхээр дотуур байрны үйлчилгээтэй холбоотой харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний албан хаагчид нь сургуулийн үйл ажиллагааны зардлаас санхүүжиж байсан. Үүнийг ингэж яг зөвхөн дотуур байранд тусад нь салгаж өгсөнтэй холбоотойгоор энэ хүсэлт бий болсон байгаа.

Д.Батбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дээрх асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүдийн нэрийг авъя.

Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүний микрофоныг нээе.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Нэлээн хэдэн төрийн албан хаагчийг авчирлаа. Тэгээд бид нар тодорхой мэдээлэл авч чадсангүй гэдэг дээр би бодож байна. Тэгээд үнэн ярих ёстой байх аа. Зөвхөн Соёл, спорт, аялал жуулчлалын яам 1.6 тэрбум долларын орлого оруулаад реклам нь зар сурталчилгаандаа нэг хэдэн төгрөг зарчихсан гэж би бодохгүй байна.

Тэгэхээр аудитад би нөгөө хэлэх гээд байгаа санал нь ер нь бол цаашдаа бид нар байна шүү дээ энэ үр дүнгээ тодорхой тооцдог болмоор байгаа юм. Одоо бид нар төсвийнхөө 1 их наяд төгрөгийг урсгал зардал дээр гаргачхаад үр дүн байхгүй.

Үр дүн гэдэг чинь тайлан биш шүү дээ. Юу гэдэг юм бид нар нэг байгууллагын дарга томилолтоор явлаа гээд ирээд нэг тайлан бичээд өнгөрөх нэг өөр. Тэгээд явсан томилолтын үр дүнд бид нар юу гэдэг юм хамтын ажиллагаагаа ингэж өргөжүүллээ ийм шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүллээ ч юм уу ийм үр дүн бид нарт хэрэгтэй байна. Энэ үр дүн талаас нь аудитад тайлан гаргаж Их Хурал руу мэдээлэл өгдөг байвал илүү үр дүнтэй болох юм болов уу гэж бодож байна. Одоо энэ жишээлэх юм бол хэмнэсэн орон тоо хэдийг хэмнэчихсэн юм. Одоо бүх юм бид нар цахим руу шилжүүлээд байна гээд байгаа. Цахим руу шилжүүлээд бид нар одоо цаг хугацаа ч юм уу зардал мөнгөний хувьд ийм хэмнэлт гаргасан байна гээд. Бүх байгууллагуудад аудит орж амжихгүй байх. Гэхдээ одоо энэ төсвийн ерөнхийлөн захирагч бүрд өөрт нь дотоод аудит байгаа. Тэгээд энэ дотоод аудитынх нь гаргаж байгаа мэдээлэл дээр үндэслээд тэр үр дүнгүүдээ ингээд нэг ийм түүврийн байдлаар ч юм уу аваад хийхэд арай нэг бодитой юм гараад үр дүнтэй байх болов уу гэдэг талаас нь харах гээд байгаа юм.

Тэгээд энэ төрийн байгууллага жишээлэхэд зар сурталчилгаа хийх ямар шаардлагатай юм. Энийг бол шууд үргүй зардал энийгээ боль гэдэг байдлаар энэ одоо аудитаас дүгнэлт гарвал их сайн байна. Төрөөс гаргаж байгаа зардал болгон иргэдэд очиж байгаа төрийн үйлчилгээ хүртээмжтэй, стрессгүй, бухимдалгүй байвал ингээд л энэ үр дүн шүү дээ. Тэгэхээр бид нар энэ талаас нь харж дүгнэлт хийдэг бол их зүгээр юм шиг санагдаад байна.

Тэгээд энэ ангилал тал дээр энэ Сангийн яаманд би бас буруу ойлгоод буруу яриад байж магадгүй. Одоо энэ 210, 801 гэдэг ангилал дотор 83.20 гэдэг зардал байна. Яг энэ Сангийн яамны зардал дотор байгаа. Нөгөө төсөл хөтөлбөртэй холбоотой гарч байгаа зардлууд гээд тэр нь дахиад 210, 804 дотроо тээврийн хэрэгслийн зардал нь дахиад л дотроо тэр төсөл хөтөлбөртэй холбоотой гээд ингээд ангилал нь давхардаад байдаг юм байгаад байдаг юм уу? Эсвэл би буруу ойлгоод байна уу гэдгийг нэг олон улсын нөгөө байгууллага эсвэл Сангийн яам зөв ойлгоод бид нар буруу ойлгоод байдаг юм байдаг байж магадгүй. Тэгээд тэрийг аль болох нэг ийм эвтэйхэн байх талаас нь бодвол гэж байгаа юм.

Тэгээд ер нь нөгөө нэг Сангийн яаманд хандаад хэлэхэд миний ойлголтоор бол хөрөнгө оруулалт гэдэг чинь өөрөө нөгөө мөнгө олоод байдаг. Одоо энэ хувийн хэвшлийнхэн бол хөрөнгө оруулалт хийнэ гэх юм тоног төхөөрөмжөө сайжруулна, ажлын байраа нэмэгдүүлнэ ч гэдэг юм уу ингээд мөнгө олдог юм руу хөрөнгө оруулалт хийхийг л хөрөнгө хөрөнгө оруулалт гээд байгаа юм. Тэгтэл манай нөгөө нэг төсөв дээр болохоор хөрөнгө оруулалтаа бид нар харахаар чинь мөнгө олдоггүй зам гүүр, цэцэрлэг, сургууль ч юм уу тэ хөрөнгө болоод байгаа юм руугаа хөрөнгө оруулалт гэдэг ойлголтоор хийгээд байхаар бас энэ ангилал дээр нь би бас буруу ойлгоод байдаг байж магадгүй. Тэгэхээр энэ дээр бас нэг зөв тайлбар өгвөл зүгээр юм болов уу гэж бодож байгаа. Тэгээд аудит л энэ үр дүнтэй холбоотой дүгнэлтүүдээ нэлээн сайн гаргачих юм бол бид нар энэчээ энэ олон төрийн албан хаагчийг энэ урт хугацаагаар суулгаад үр дүнгүйгээр хуралдаад байхгүй л юм болов уу гэж харах гэж байгаа юм.

Д.Батбаяр: Өнөөдөр Төсвийн зарлагын хяналтын дэд хорооныхоо хуралдаанаар бид нар энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны улсын төсвийн урсгал зардлын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зарцуулалтын талаар мэдээллийг сонслоо. Тэгээд үүгээр төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах, шаардлагагүй зардлуудыг төлөвлөж байгаа эсэхийг нь

тодруулах тэвчиж болох зардлуудыг танах замаар төсвийн нэг тэнцлийг сайжруулах боломжтой эсэх талаар бодитой үнэн зөв дүгнэлт гаргах, мэдээлэл авах, улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах болон ирэх оны улсын төсвийн төслийг боловсруулах явцад анхаарах асуудлуудыг тодорхой чиглэлээр мэдээллийг гишүүдэд хүргэх ийм зорилготой мэдээллийн хурал боллоо.

Энэ бол анх удаагаа хийгдэж байгаа хурал учраас тодорхой хэмжээгээр энэ зорилгоо хангасан хурал боллоо гэж харж байна. Тэгээд өнөөдрийн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдааны үеэр Сангийн яамнаас энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн ангиллын зардлын талаар эрх зүйн орчин болон олон улсын харьцуулсан туршлага төсвийн төрлүүдээр задлан дүгнэлт хийж цаашид цахимжуулалтын үр дүнд холбогдох зардлыг зарцуулалтад шинжилгээ хийх боломжтой талаар мөн Үндэсний аудитын газраас энэ тухайн сэдвийн хүрээндээ шаардлагатай мэдээллийг өгсөн.

Хамгийн өндөр өссөн төсөвтэй төсвийн ерөнхийлөн захирагч нарын цаашид анхаарах асуудлаар зөвлөмж саналаа танилцууллаа.

Энэ хуралд оролцсон эрх бүхий байгууллагын өгсөн мэдээллийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүд энэ төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийг нарийвчилсан байдлаар судлан үзэх боломжоор хангах, мөн 2024 оны төсвийн гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний ангилалд тусгагдсан 957 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хэдэн хувь буюу хэдэн төгрөгийн санхүүжилт нэгэн шилэн дансанд бүртгэгдсэн талаар мөн асуулаа. Төсвийн зардал талд тусгагдаж эдийн засгийн ангилал болон дээрх эдийн засгийн ангилалд тусгагдаж байгаа үйл ажиллагаануудын зардлуудыг зөв тооцож байгаа эсэхээр мөн тодруулж асуусан. Төрийн сангийн гүйлгээнд цахимжилтыг хэрхэн ашиглаж байгаа талаар болон дээрх гүйлгээг Аудитын байгууллагаас бүрэн хянаж байгаа эсэх дээр мөн асуулаа. Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг Улсын Их Хурлын нарийвчлалын эдийн засгийн ангилал бүрээр нь судалж үзэх боломжтой эсэх талаар мөн асуулт асууж хариулт авлаа.

Мөн эрдэм шинжилгээ судалгаа болон мэдээлэл сурталчилгааны ажил дээр хэтэрхий өндөр төсөв тавигдаж байгаа. Мөн энэ эдгээр ажлуудын үр дүнгийн талаар мөн асуулт асуусан хариулт авлаа. Аудитын байгууллага зөвлөмж дүгнэлтдээ цаашид анхаарах талаар тус тус улсын төсвийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, ангиллын зардлын талаар мөн ахиж асуулт асуусан.

Мөн тодорхой хэмжээний саналуудыг гаргалаа. Тэгээд улсын төсвийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, ангиллын зардал, 2024 оны гүйцэтгэлээр энэ дахиж явж байна тийм үү. 957 тэрбум буюу өмнөх оноосоо 36 хувиар өсчихсөн байгаа. Жил бүр энэ зардал өсөөд яваад байгаа юм. Үүний дотор дийлэнх төсвийн ерөнхийлөн захирагчид нь болохоор мэдээлэл сурталчилгааны зардал гээд түрүүн би сая дурдсан гишүүд мөн дурдсан. Мэдээлэл сурталчилгааны зардал гэдэг дийлэнх хувийг нь эзэлж байна. Эрдэм шинжилгээний зардал, судалгааны ажил гээд. Бодлого боловсруулах ёстой. Захирагч энэ төсвийн ерөнхийлөн захирагчид маань эрдэм шинжилгээ, судалгааны ажил гээд нэлээн их хэмжээний төсвийг суулгасан байна.

Мэдээлэл технологийн үйлчилгээ, байр ашиглалт, газрын төлбөр, тээврийн хэрэгслийн татвар зэрэг ангиллын зардлууд л яг тогтмол өсөж байна. Эдгээр

зардлын зарцуулалтын үндэслэл шаардлага нь тодорхойгүй байна. Төлөвлөлт нь сул байна, зарцуулалт нь хангалтгүй байна. Үр ашиггүй зарцуулалт байгаа нь энэ ангиллын зардлын талаарх мэдээлэл хийх үндэслэл болж энэ талаар холбогдох байгууллагуудын тодорхой мэдээллүүдийг өнөөдөр бид нар сонссон.

Жишээг бол аль хэдийн бид нар асуулт хариултын үеэр дурдсан байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлаар баталсан энэ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023 оны 93 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолын утга нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэж улирал бүр мэдээлэх хэрэгжилтийг хангуулах, төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр төлөвлөн хөтөлбөр арга хэмжээний үр дүн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж түүнтэй уялдсан төсвийн зардлыг тооцож боловсруулж байхаар тус тус заасан байна.

Тэгээд өнөөдрийн мэдээллээс харахад урсгал зардлыг хэт ерөнхий төлөвлөсөн зардлуудыг эдийн засгийн ангиллаар нь арга хэмжээ тус бүрээр нь нарийвчлан ахиж төлөвлөх, төсөвлөх зарцуулалтад тавих, санхүүгийн гүйцэтгэлийн хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх. Эцсийн үр дүнтэй уялдуулах үүний тулд гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтийг нарийвчлан тогтоож улсын урт, дунд хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүнтэй уялдсан төлөвлөлт хийх шаардлагатай байна гэж үзэж байна. Үүнээс чухал нь эргээд түүнийгээ дүгнэх боломжтой болох шаардлагатай байгаад байна. Мөн бүх шатын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагаа дээшлүүлэх, аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг холбогдох хуульд нийцүүлэн хийдэл зөрчлийг нь арилгуулах зэрэг арга хэмжээг авдаг баймаар байна.

Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын нэрийн өмнөөс улсын төсвийн зарцуулалтад хяналт тавих эрх бүхий Үндэсний аудитын газар гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангуулдаг байх, Улсын Их Хурлаас төсвийн зарлага түүний гүйцэтгэлтэй холбогдуулан тодорхой асуудлаар мэдээлэл судалгаа шаардах цаг хугацаанд нь чанартай мэдээллээр хангаж парламентын төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэх ажиллах нь зүйтэй байна гэж хувийн зүгээс үзэж байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хурлыг хаасныг мэдэгдье ээ.

Өнөөдрийн хуралд оролцсон гишүүд болон ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье ээ.

19.12 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

